

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-34

| | |
|--|-------|
| 1.“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох | 4-30 |
| 2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ | 30-32 |
| 3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ | 32-33 |
| 4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/ | 33-34 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 44 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг;
Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, Ц.Идэрбат,
Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Ж.Чинбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, С.Лүндэг, М.Мандхай.

Нэг. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Б.Уянга, Н.Наранбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, С.Замира, С.Ганбаатар, Ж.Батжаргал, Б.Бейсен нар үг хэлэв.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Т.Жамбалцэрэн, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, У.Отгонбаяр нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Бейсен хариулж, тайлбар хийв.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 03 минут үргэлжилж, 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 44 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 54,2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн /БОХХАА-н/ байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн байна, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна, Гомбын Ганбаатар 7 дугаар тойрог ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна, Сонгобайн Замира жагсаалтаар ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн байна, Бадрахын Найдлаа жагсаалт ирсэн байна, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж 7 дугаар тойрог ирсэн байна, Агваанлуvsангийн Ундраа гишүүн жагсаалтаар ирсэн байна, Болдын Уянга жагсаалтаар ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн /ХХААХҮ-ийн/ сайдын мэдээллийг сонсох. 2 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай. 3-д Байнгын хорооны тогтоолын төсөл Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай. 4 дүгээрт Байнгын хорооны тогтоолын төсөл Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалд орёе.

Нэг. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын

хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2022 оны 36 тогтоолын хэрэгжилтийн явц байдлын талаарх ХХААХҮ-ийн сайдын мэдээллийг сонсьё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны ТНБД, Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлого хэрэгжилт зохицуулах газрын дарга, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга. Мэдээллийг ХХААХҮ-ийн сайд Энхбаяр танилцуулах ёстой боловч ар гэрийн гачигдалтай, ээж нь сэхээнд ороод сая албан ёсоор чөлөө авлаа. Тийм учраас яамны ТНБД Жамбалцэрэн мэдээллийг танилцуулъя. 5 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Өнөөдөр дэлхий дахинд үүсээд байгаа геополитикийн хурцадмал байдал, цар тахлаас шалтгаалсан үр дагавар, тээвэр логистикийн хүндрэл, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэрэг дэлхий нийтийн хүнсний хангамж аюулгүй байдалд томоохон сорилт бэрхшээлүүд дагуулж байна. 2022 онд хийсэн НҮБ-ын судалгаагаар дэлхийн 23 орны 193 сая хүн ам хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орсон. Энэ тоо ганцхан жилийн дотор 40 сая хүнээр нэмэгдсэн судалгааны үр дүн гарсан байна. Дэлхийн хэмжээнд хүнсний хангамж, аюулгүй байдалд эрсдэлд орж байгаатай холбогдуулан улс орнууд энэ тал дээр тодорхой онцгой анхаарч, хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлэх олон улсын байгууллагуудыг уриалсан уриалга гаргасаар байна.

Тус уриалгыг Монгол Улс цаг алдалгүй хүлээн авсан анхны улс орнуудын нэг бөгөөд нөхцөл байдал энэ онд ч гэсэн сайжрахгүй төлөвтэй байгааг олон улсын байгууллагуудаас анхааруулж байгаа. Хүн амыг эрүүл хүнсээр тогтвортой хангах зорилгоор Монгол Улсын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг баталж, үүний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг бэлтгэн та бүгдэд танилцуулахад бэлэн болсон байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан 100 жил 100 зорилт хөгжлийн санаачилга, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр Алсын хараа 20 50 бичиг баримт, мөн Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд хүнсний гол нэрийн хүнс, гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутгаа хүнс экспортлогч орон болох зорилтыг тавьж, хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг орон даяар хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан.

Тус үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш 2 жил гаруй хугацаанд ХХААХҮ-ийн салбарт тодорхой ахиц үр дүнгүүд гарсаар байна. Хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, хүнс, хөдөө аж ахуйн салбарт салбарт мэргэжилтэн бэлтгэж байгаа их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, ажиллагсдыг давтан сургах, мэргэжил арга зүйг дээшлүүлэх, урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулах нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний тээвэр логистик, ачаа тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх, агуулахын сүлжээг нэгдсэн удирдлага дор зохион байгуулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын бүтэц, тогтолцоог

шинэчлэх, мэдээллийн цахим сангийн тогтолцоог бий болгох зэрэг тодорхой анхаарах шаардлагатай үйл ажиллагаанууд хэрэгжилтийн явцад гарч байна.

Мөн аймаг, нийслэл, орон нутагтаа хүнсний хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, Хүнсний тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлын үр дүнг үнэлж, хангалтгүй байгаад нь хариуцлага тооцох, ахиц дэвшил гарч байгаад нь дараагийн шатанд нь шилжүүлж дэмжлэгийн шинэ бололцоог гаргах, хүнсний хангамжийн зээлийн хэрэгжилтийн үр дүнг тооцож, дараагийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авах шаардлага бий болж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 19 нэр төрлийн бүтээгдэхүүний зүйл, заалт бүрээр ХХААХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн дарга танилцуулна. 5 номер дээр.

Б.Бейсен: 4 номерын микрофон.

Д.Довчинсүрэн: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн миний бие та бүхэндээ Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн талаар та бүхэндээ илтгэл танилцуулъя. Хүн амаа дотоодод үйлдвэрлэсэн эрүүл аюулгүй хүнсээр хангах, хүнсний хангамжийн тогтвортой байдлыг сайжруулах, бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний хувьсгалыг санаачлан орон даяар хэрэгжүүлээд 2 жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд оролцогч талуудын хамтын ажиллагааны үр дүнд мэдэгдэхүйц тодорхой үр дүнгүүд гарч байна. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд үйлдвэрлэл цехүүд шинээр баригдаж, шинэ шугамууд үйлдвэрлэлээ өргөтгөж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнээр зах зээлд нийлүүлэгдэж, ХХАА-н үйлдвэрлэлд уг тогтоол нэлээн өгөөжөө өгч байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан батлуулсан Улсын Их Хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдалд авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний сүлжээний бүх үе шатад аюулгүй байдлыг хангах, хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл түүхий эдийн дотоодын нөөцийг ашиглалтыг нэмэгдүүлэх, импортын хамаарлыг нь бууруулах, цаашид хүнс экспортлогч орон болох зорилтыг дэвшүүлсэн байгаа. Энэхүү тогтоол нь эрх зүйн удирдлага, зохион байгуулалт, газар тариалан, мал аж ахуй, хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр бүхий 5 зорилтын хүрээнд 41 үйл ажиллагааны чиглэлд 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд ХХААХҮЯ дангаараа хэрэгжүүлэхээр 90, хамтран хэрэгжүүлэх 17 арга хэмжээ хэрэгжилтийг бол дунджаар хэрэгжилтийн дундаж нь 61,8 хувьтай гүйцэтгэл явагдаж байна.

ХХААХҮ-лэлийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр нийт 10 хуулийн төсөл боловсруулсан ба манай яам 8 хуулийн төслийг ахлан ажиллаж, 3 хуулийг Улсын Их Хурлын чуулганаар батлуулж, 3 хуулийн үзэл баримтлалыг нь батлуулсан. 1 хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2 сайдын хамтарсан тушаалыг батлуулсан. 3 хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулаад байна. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3153 ААН-д 1,2 их наяд төгрөгийн зээлийг болон эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийг олгоод байгаа байна. Нийт энэ зээлийн эх үүсвэрийн ашиглалт 98 хувьтай байгаа бөгөөд зээлийн хүсэлтийн 50 хувийг шийдвэрлэгдсэн зэрэг зээлтэй холбоотой тойм мэдээг энэ хэсгээс харж болохоор байна. 2025 оны яамны төсөвт 88,2 тэрбум төгрөг 36 дугаар тогтоолын хүрээнд суугдсан бөгөөд үүнээс 2023 онд олгогдсон 832,7 тэрбум төгрөгийн зээлийн

хүүгийн дэмжлэгт 40,9 тэрбум төгрөг, 2024 онд олгогдсон 428,7 тэрбум төгрөгийн 47,2 тэрбум төгрөгийн хүүгийн тэр дэмжлэгийг нь энэ 2025 онд хийгдэхээр байгаа.

Олгогдсон зээлийн мэдээллээс харахаар энэ газар тариалангийн салбарт хамгийн олон ААН-д зээл олгосон бол мөнгөн дүнгээр нь ингээд хараад үзэхээр хүнсний салбар нийт батлагдсан зээлийнхээ 65 хувийг нь олгочихсон байгаа. Газар тариалангийн салбарт олгосон зээлийн үр дүнг 3 үзүүлэлтээр нь ингээд харуулсан байгаа. Нийтдээ зоорины багтаамжийн хувьд төмс, хүнсний ногооны механикжсан агуулах зоорины багтаамж 2024 онд 292,2 мянган тонн болж 2022 оны суурь түвшнээсээ 37,2 мянган тонноор нэмэгдсэн тийм таатай мэдээ байгаа. Мөн үр тарианы үтрэмийн багтаамж, үр цэвэрлэгээний иж бүрэн автомат механикжсан үтрэмийн багтаамж 2024 онд 557,3 мянган тоннд хүрч 2022 оны суурь түвшнээсээ 34,3 мянган тонноор нэмэгдсэн ийм өсөлттэй тийм дүр зураг харагдаж байгаа.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тариалангийн талбайн ажлын механикжилт, механикжуулалт, технологит ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлж ажиллалаа. Энэ хүрээндээ үр тарианы техник шинэчлэлийг 2022 онтой харьцуулахад 20 хувиар нэмэгдсэн. Төмсний техник шинэчлэл 15 хувиар нэмэгдсэн. Хүнсний ногооны техник шинэчлэлд нийтдээ 12 хувиар нэмэгдсэн тийм дүр зургууд гарсан. Хүлэмжийн аж ахуйн хувьд 2019 онд 59,4 га-д, 2024 онд 114,4 га талбай бүхий зуны хүлэмжид нарийн ногооны тариалалтыг хийсэн бөгөөд нийтдээ 96, 2019 онд 96 га-д тариалж байсан бол 2024 онд 154,4 га-д тариалаад нийтдээ ингээд 60 хувийн өсөлттэй явж байгаа. Энийг нь өвлийн хүлэмжийн тариалалт 28,6 га-д тариалж байсан бол одоогийн байдлаар 2024 онд 39,1 га-д тариалалт хийгдэж байгаа. Нийтдээ энэ зуны хүлэмжийн тариалалтыг 115,4 га-д тариалж байгаа бол энийгээ 100 га-гаар нэмэгдүүлээд яг зорилтот түвшин буюу 26 оны сүүл гэхэд 215 га болгоод, 39,1 га-д тариалж байгаа хүлэмжийг өвлийн хүлэмжийн тариалалтыг 50 га-гаар нэмэгдүүлээд ингээд нийтдээ 305 га-д хүлэмжийн тариалалтыг хэрэглэх юм бол бид дотоодоосоо яг энэ хүлэмжийн ногоо буюу энэ нарийн ногоогоо дотоодоосоо хангах бүрэн боломжтой гэсэн тооцоо судалгаа гарч байгаа. Яг энэ зорилтод хүрэхээр бид ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн хэмжээ гэхэд 2019 онд 5803 тонн үйлдвэрлэж байсан бол 2024 онд 13500 тонн буюу 2,3 дахин тийм өсөлттэй харагдаж байгаа. Тэгээд энэ 2026 онд 30 10-н 30800 тоннд ингээд хүргэчих юм бол, хүргэнэ гэсэн тийм зорилттой байгаа. Тэгээд 2020 онтойгоо харьцуулсан 2020-г 24 онтойгоо харьцуулсан судалгаагаар өргөст хэмх 60 хувир нэмэгдсэн улаан лооль 23 хувиар нэмэгдсэн, навчит ногоон 4 дахин нэмэгдсэн, чинжүү гэхэд 45 хувиар нэмэгдсэн гээд нэлээн тийм өсөлттэй дүр зургууд энэ 24 онд гарч ирсэн.

Гол нэр төрлийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлийн 2024 оны урьдчилсан гүйцэтгэлийг 2027 онтой харьцуулсан дүнг та бүхэн ингээд харж байна. Түүхий эдийн 3 стратегийн хүрээнд явагдаж байгаа түүхий эдийн давуу талыг нь ашиглахаар Монгол Улс сүү, малын мах, төмс, гурилан бүтээгдэхүүнээр дотоодынхоо хэрэгцээг 100 хувь хангаж байгаа. Хангаж байгаа хэдий ч гурил энэ 24 онд 59 хувьтай үйлдвэрлэл явагдсан. Энэ маань гаалийн албан татвараас хугацаагүйгээр гаалийн албан татвараас чөлөөлсөнтэй холбогдуулаад 59 хувьтай үйлдвэрлэл явагдаж, нэлээн буурсан үзүүлэлт гарч ирсэн. Энэ жил 64 мянган тонн гурил импортоор орж ирсэн байна лээ. 2023 онд 450 тонн орж ирж байсан бол энэ ингэж огцом нэмэгдэж ингэж орж ирсэн нь энэ гурилын үйлдвэрлэл дээр нэлээн сөрөг нөлөө үзүүлсэн харагдаж байгаа. Бодит хэрэгцээ байгаа боловч энэ гурил,

гурилан бүтээгдэхүүн, сахар, хүнсний ногоо, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүн, ургамлын тос, цөцгийн тос, шувууны мах гээд эдгээр бүтээгдэхүүнүүд ерөнхийдөө өсөлттэй. Яг энэ 36 дугаар тогтоолын хүрээнд нэлээн тийм өсөлттэй дүр зургууд энэ 2024 онд гарч ирсэн.

Тэгээд энэнийхээ өсөлтийг цааш нь нэмэгдүүлэхийн тулд импортын хамаарлыг нэлээн бууруулж, бид энэ дотоодынхоо хангамжийг нэмэгдүүлэх том зорилтоо тавиад явж байгаа. Бусад энэ жимс жимсгэнийн зүйл 3 хувьтай байсан бол 1 хувийн өсөлтөөр нэмэгдсэн. Төрөл бүрийн будаа яг 0 хувь дээр байгаа. Бид сая газар тариалан эрхлэгч нартайгаа нэлээн хэдэн уулзалтуудыг хийгдсэн. Энэ хүрээндээ сэлгээний таримлыг тарималжуулах асуудлуудыг 1 дүгээрт яригдаж байгаа. Энэ дээр буурцагт ургамал, мөн ялангуяа төрөл бүрийн будаанаас гурвалжин будааг Монгол Улсад бүрэн тариалах боломжтой гэсэн тийм судалгаа гаргасан учраас энэ 2025 онд гурвалжин будаа нэлээн түлхүү тариалагдаж энэ тоо энэ зорилтот түвшиндээ хүрэхэд нэлээн нэмэгдэнэ гэсэн тийм байгаа.

Хүнсний салбарт олгогдсон зээлийн үр дүн, үр дүнд шинээр 39 үйлдвэр шинээр бий болсон байгаа. Үүнээс ингээд сүү боловсруулах үйлдвэр 8 болсон бөгөөд Архангай аймагт 2, Төв аймагт 1, Сэлэнгэд 1, Улаанбаатар хотод 4 гээд. Мах төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр 10 шинээр бий болсон. Энэ дээр Баян-Өлгий аймагт 1, Баянхонгор аймагт 1, Дархан-Уул аймагт 1, Төв аймагт 1, Улаанбаатар хотод 2, Хэнтийд 3, Сүхбаатар аймагт 1 гээд. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр Архангай аймагт 1 гээд нийтдээ 12 үйлдвэр шинээр бий болсон. Тэгээд энэ 36 дугаар тогтоолын хүрээнд Дархан-Уул аймагт 1, Улаанбаатар хотод 9, Дорноговь аймагт 1 байгаад байгаа. Бусад нэр төрлийн бүтээгдэхүүнүүд буюу сав баглаа боодлын үйлдвэрлэл 2, давсны боловсруулах үйлдвэрлэл 1, ус, ундаа, шүүсний үйлдвэр 4, жимс жимсгэнийн боловсруулах үйлдвэр 2 гээд нэг ийм үр дүн нэлээн ахицтай гарч ирж байгаа.

Энэ шинэ үйлдвэрүүдийн хувьд бид 500 сая төгрөгөөс дээш хөрөнгө оруулалтын зээл авсан, мөн тэрбумаас дээш хөрөнгө оруулалтын зээл авсан ААН-тэй бодлогын хяналтын гэрээ байгуулагдаж байгаа. Яг энэ гэрээ байгуулагдсан энэ шинээр үйлдвэрүүд нь энэ томоохон үйлдвэрүүд нь ингээд 39 үйлдвэр байгаа. Харин тэрнээс жоохон доогуур хяналтын гэрээ байгуулаагүй үйлдвэрүүд маш их байгаа. Энэ 36 дугаар тогтоолын үр дүнд. Энийг ингээд оролцуулаад тооцвол нэлээн 100-гаад үйлдвэр цехүүд ашиглалтад орсон гэдэг таатай мэдээ байна.

Агуулахын шинээр байгуулсан бол 1 ААН 1440м²-аар шинэ өргөтгөл явагдсан, шинээр бий болсон. Өргөтгөлийг 33240м²-аар 3 ийм импортын хүнсний агуулах нэмэгдсэн. Хүнсний үйлдвэрлэлийн өргөтгөл 7 үйлдвэр өргөтгөл хийгдэж, нийтдээ 7740м²-аар нэмэгдсэн. Энэ нь Ховд аймаг, Хөвсгөл, Дархан, Улаанбаатар, Дорнод аймгууд дээр явагдсан байгаа. ХХААХҮ-ийн тоног төхөөрөмжийн гаалийн албан татвараас хөнгөлөлт үзүүлэх ЗГ-ын 2023 оны жагсаалт батлах тухай 107 дугаар тогтоолыг 2023 онд баталсан. Энэ тогтоолын хүрээнд нийтдээ 249 ААН-үүд 219,6 тэрбум төгрөгийн импортын бараа бүтээгдэхүүн шинэ тоног төхөөрөмжүүдийг оруулж ирсэн. Үүнээсээ 13 тэрбум төгрөгийг буцаан олголтыг буцаж авсан. Энэ нь ААН-үүд дээр маш том дэмжлэг болж байгаа.

Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний биет үйлдвэрлэлийг нь 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 22, 23 онтой харьцуулсан графикайг та бүхэнд харуулж байна. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас, зудын улмаас малын тоо буурсан, мах бэлтгэлийн тоо хэмжээ нэлээн нэмэгдэж, экспорт нэмэгдсэнтэй

холбогдуулаад хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн махны хэмжээ буурсан хэдий ч үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ нэмэгдсэн байгаа. 2023 онд 49,5 мянган тонн байсан бол 2024 онд 50,2 мянган тонн хүрч ингээд нэмэгдсэн байгаа. Гурил үйлдвэрлэлийн хувьд түрүүн би хэлсэн. 2023 онд импортоор 450 тонн орж ирж байсан бол сая Гаалийн албан татвар чөлөөлөх хууль гарсантай холбогдуулаад гурилын үйлдвэрлэл нэлээн буурсан бөгөөд гурилын үйлдвэрлэл 27 хувиар буурсан. Газар тариалан дээр нэлээн бууралттай үүсгэрүүд гарч ирсэн байгаа.

Сүүний үйлдвэрлэлтийн хувьд яг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн сүүний үйлдвэрлэл 23 онтойгоо харьцуулах юм бол 10 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Төмсний тариалалт 2023 онтойгоо харьцуулаад ингээд үзэхээр төмсний тариалалт 46 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Хүнсний ногооны хувьд мөн адил 25 хувийн өсөлттэй буюу нэлээн тийм дээшээ өсөлттэй, 36 дугаар тогтоолын хүрээнд нэг өсөлттэй зүйлүүд нэлээн ажиглагдаж байгаа. Хүнсний үйлдвэрлэлийн борлуулалтын орлого суурь 2022 оны 1 тэрбум 703, 1 их наяд 703 мянган төгрөгтэй тэрбум төгрөг байсан бол нийтдээ яг энэ 2024 онд 2 тэрбум, 2 их наяд 784 мянга тэрбум төгрөгийн буюу 63,4 хувиар өсөлттэй ийм борлуулалтын орлого нэмэгдсэн байгаа.

Хүнсний экспортын шинээр эрх авсан ААН нэг цонхны цахим систем эд нар гээд хүнсний гол нэр төрийн бүтээгдэхүүний гадаад худалдааны чиглэлээр нэлээн үйл ажиллагаа явагдсан. Экспорт 13,9 хувиар нэмэгдсэн зураглал гарч байгаа ХАА-н салбарын гадаад худалдаа дээр. Импорт болохлоор жоохон өссөн дүр зурагтай харагдаж байгаа. Эндээс хүнсний экспорт, импортын харилцаа экспорт 17466 мянган тонн байсан бол одоо 4,1 дахин нэмэгдэж 72572 мянган тоннд хүрсэн. Импортын энэ өсөлт нь болохоор 2022-оос 23 оны хувьд импорт буурсан үзүүлэлттэй байсан бол энэ жилийн хувьд нөгөө тал эргээд нөгөө гурилын албан татварын чөлөөлсөн хуультай холбогдуулаад 18,7 хувь нь гурилын чөлөөлсөн хуультай холбогдуулаад энэ өсөлттэй дүрүүд гараад ирж байна. Тэгээд хүнсний ногоо болохоор Монгол Улсын хувьд нэлээн хүнсний ногооны эрэлт хэрэгцээ нэлээн нэмэгдэж байгаа. Хүлэмжийн ногооны тариалалт нэмэгдэж байгаа хэдий ч яг энэ өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээнд зориулаад хүнсний ногооны хэрэгцээ нэлээн нэмэгдэж байгаа дүр зургуудаар энэ импортын хэмжээ жоохон өссөн юунууд харагдаж байна лээ.

Экспортын орлогод Монгол Улсын экспортын орлогод хүнс, хөдөө аж ахуйн салбар 5 хувийг нь эзэлж байгаа. Эндээсээ хөнгөн үйлдвэрлэл 52 хувийг нь, мал аж ахуй 26 хувийг нь, газар тариалан 9 хувийг, хүнс 13 хувь гэж байгаа. Импортод эзлэх хувиар нь бодвол 13,4 хувь, ингээд хүнс 56 хувийг, хөнгөн үйлдвэрлэл 19 хувийг нь, мал аж ахуй 12 хувь, экспорт, импорттой ингээд харьцуулахаар хөнгөн үйлдвэрлэл 52 хувь, импорт нь болохоор хүнсний үйлдвэрлэл 56 хувь гэсэн нэг ийм дүр зургууд харагдаж байна лээ. Экспорт, экспортын талаар бид 3 арга хэмжээ авагдсан байгаа. Энэний хүрээнд экспорт нэлээн тийм сайжраад, сайжирсан дүр зургууд харагдаж байгаа. Мах, махан бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг хязгаарлалтгүй болгосон. Үүний хүрээнд 2022 онд 16 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолж, 50 сая ам.доллараар экспорт явагдаж байсан бол 2024 онд 71,1 мянган тоннд хүрч 285,4 сая ам.доллараар экспорт хийгдсэн байгаа.

Мөн БНХАУ-д хүнсний түүхий эд бүтээгдэхүүн экспортлох ААН-үүдийнхээ тоогоо нэлээн нэмэгдүүлсэн. Импортлогч орных нь ийм шаардлага нийцсэн ААН-үүд экспортлох эрх нь үүсдэг. Яг энэ хүрээндээ бид мах, махан бүтээгдэхүүн

экспортлогч 9 ААН-ийг нэмэгдүүлсэн. Мөн энэ самар экспортлогч 5 ААН-ийг БНХАУ-тай бүртгүүлсэн. Мөн загас экспортлогч 1 ААН-ийг нэмэгдүүлсэн. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1 ААН-ийг нэмэгдүүлсэн. Энэ хүрээндээ нэг экспорт нэлээн нэмэгдэж явагдаж байгаа. Мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагааг нэг цонхны цахим системийг нэвтрүүлсэн. Яг энэ хүрээндээ яг давхардсан тоогоор 7 ААН-д 56 бичиг баримтыг бүрдүүлж, 13 хоног зарцуулдаг байсныг нь бид цаасны давхардлыг байхгүй болгосон. Энэ хүрээндээ 13 хоногт хийгддэг байсан хоног хугацааг 8 цагийн дотор шийдвэрлэдэг болгож нэг цонхны цахим систем бий болгосон. Анхаарал тавьсан та бүхэндээ баярлалаа.

Б.Бейсен: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү? Батжаргал гишүүнээр тасалъя. Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе. Мэдээлэлтэй холбогдуулаад ганц нэг зүйл тодруулъя, тодруулж асууя. Саяын мэдээлэлд дурдсанаар би энэ хүлэмжийн аж ахуйн чиглэлээр ганц нэг асуулт асуух гэсэн юм. Хүлэмжийн тариалалт 24 онд 60 хувиар, үйлдвэрлэл 2,3 дахин нэмэгдсэн гэж байна. Үүнээс огурцы 60 хувиар, помидор 23 хувиар, навчит ногоо 4 хувиар 4 дахин, чинжүү 45 хувиар нэмэгдсэн гэсэн ийм тоон үзүүлэлтүүд гарсан байна. Тоон үзүүлэлт гарах нэг асуудал. Энийг хэрэглэгчдэд хүргэх ямар ажил зохион байгуулж, яагаад гэвэл энэ хүлэмжийн нарийн ногоонууд өөрөө удаан хугацаанд хадгалахад их төвөгтэй бүтээгдэхүүнүүд. Тийм учраас энийг хэрэглэгчдэд энэ тэр дундаа энэ өвлийн улиралд, өвөл, хавартаа хүргэх чиглэлээр ер нь ямар ажил зохион байгуулсан бэ гэдгийг би 1 дүгээрт тодруулъя. Тэгээд энэ асуултаа хариултаа авч байгаад, араас нь тодруулах зүйлээ тодруулъя.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Ц.Болорчулуун: ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хүнсний 36 дугаар тогтоолын нэг яг эхний тавьсан зорилт гол онцлогийн нэг нь энэ хүнсний хангамжийн асуудлыг сүлжээ бүрд нь дэмжлэг үзүүлэе гэдэг энэ том концепцыг дэвшүүлсэн байгаа. Тэгэхээр зөвхөн хүнсний гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангана гээд тариаланчдад зээл олгох биш, энэ дээр тээвэр логистик дээр нь, хадгалалт дээр нь, борлуулалт дээр нь гээд сүлжээ бүхэнд нь дэмжлэг үзүүлэе гэдэг ийм арга хэмжээг анхнаас нь тусгаж явсан.

Тэгээд мэдээж шинэ ургацын ногоогоор хэрэглэгчдийг тасралтгүй хангах нь бидний том зорилго. Бид нийтдээ 50 га өвлийн хүлэмжийг нэмэгдүүлж байж жилийн турш шинэ ургацын ногоогоор буюу энэ хүлэмжид тариалдаг үндсэн 4 төрлийн таримал байгаа лооль, хэмх, чинжүү, навчит байцай гээд. Энэ 4-өөр хангамжийнхаа хувийг тодорхойлж гаргаж байгаа. Ингэхийн тулд нөгөө талд нь бид хүнсний ногооны зоорь дээр тодорхой хэмжээний дэмжлэгүүдийг үзүүлсэн. Ингээд 22-оос 23, 24 онд нийтдээ хүнсний ногооны зоорь дээр нийт 55 мянган тонноор нэмэгдүүлэе гэж зорилго, зорилт дэвшүүлсэн. 32, 3 мянган тонны зоорийг нэмэгдүүлэх чиглэлд ААН-үүд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг авсан байгаа. Ингээд бид хадгалалтаа тариалалтаас гарч байгаа ногоогоо хадгалж байж энэ байнгын хэрэглэгчдэд хүрэх ийм боломжийг бүрдүүлнэ гэдгээрээ энэ онцлог байгаа байгаа. Ингээд сүлжээ бүрд нь тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлээд тухайлбал яг хүнсний ногоо тариалдаг хэд хэдэн сумдууд дээр тариаланчид өөрсдөө энэ зоорины агуулах дээр агуулахынхаа хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд энэ зээлд нэлээд хамрагдаад явсан.

Тухайлбал Төв аймгийн Борнуур сум төмсний тариалалтыг Жаргалант сум дийлэнхийг нь хийж байгаа. Энэ дээр төмсний тариалалт хийдэг ААН-үүд энэ дээр энэ зоорины зээлд нэлээдгүй хэмжээгээр хамрагдсан. Ийм учраас бид энэ хүнсний ногооны хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын асуудал дээр нь анхаарч, энэ зоорь дээр тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлснээр энийг хэрэглэгчдэд хадгалж хүргэх ийм боломжийг бүрдүүлнэ гэж. Энэ чиглэлд нь анхаарч ажилласан байгаа.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Энэ ганц хадгалалт, зоорины асуудал гэхээсээ илүүтэйгээр өрхийн хэмжээнд энэ нөөшлөх, хадгалах, даршлах чиглэлийн сургалт семинаруудыг энэ орон нутагт, тэр дундаа орон нутагт нэлээдээр зохион байгуулах зайлшгүй шаардлага байгаа юм. Бид бүхэн их том, том тоонууд яриад л, тэд дахин өссөн, хэд дахин өссөн, тэдэн хувиар өссөн л гээд л том, том тоонууд л яриад байгаа болохоос яг амьдрал дээр тэр нь айл өрхөд хүрч байгаа юм нь ний нуугүй хэлэхэд их бага л байх шиг байгаа юм. Тэгээд жишээ нь улаан лооль гэхээр Дэвшлийн улаан лооль гэсэн нэртэй хамгийн үнэтэй помидорыг өвөл, хавартаа л иддэг. Тэгээд тэр нь үнэхээрийн дэвшлийн помидор мөн юм уу, биш юм уу тэрийгээ ч мэдэхгүй. Тийм учраас бид бүхэн энэ өрхийн үйлдвэрлэл.../минут дуусав/

Б.Бейсен: Отгонбаяр гишүүнд 1 минут болгоё.

У.Отгонбаяр: Тэгэхээр тэр дундаа энэ орон нутагт энэ өрхийн үйлдвэрлэлийг та бүгд маань түлхүү, өрхийн үйлдвэрлэл рүү түлхүү анхаарч өгөөч. 10 айл дундаа нэг хүлэмжтэй эсхүл айл болгон хүлэмжтэй энэ загвар луу орж чадвал араас нь залгуулаад тэр даршлах, нөөшлөх чиглэлийнх нь сургалт семинаруудыг нь хамтад нь явуулаад. Аймаг, сум болгонд Хөдөө аж ахуйн мэргэжилтэн байгаа шүү дээ. Эд нарйгаа нэгдсэн зохион байгуулалтад оруулаад сайхан намартаа нарийн ногоонуудаа помидор, огурцы, помидор, чинжүүгээ хурааж аваад, тэрийгээ сайхан нөөшлөөд, өвөлжин, хаваржин идээд, дараагийнхаа шинэ ногоотой залгадаг ийм л юм руу ормоор байгаа юм. Тэгэхгүй бол юу гэдэг юм Хөдөө аж ахуйн яам бол том үйлдвэрлэгч нөгөө массаар үйлдвэрлэдэг өвлийн хүлэмж рүүгээ нэлээн түлхүү анхаараад байх шиг байгаа юм. Энэ нь нэг талаараа зөв. Гэхдээ эхний ээлжид өрхийн түвшинд энэ асуудлуудыг нь шийдэж чадвал бид бүхэн энэ хүнсний аюулгүй байдал, эрүүл, баталгаатай хүнс хэрэглэх тэгээд.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Отгонбаяр гишүүний асуултад тодруулж хариулъя. ХХААХҮЯ-ны ТНБД Жамбалцэрэн. Хүнсний хөтөлбөр хэрэгжээд энэ хэрэгжилтийн хугацаанд 2,5 жил өнгөрч байна. Тэгээд энэ суурь түвшинтэй нь хүрсэн үр түвшнийг харьцуулаад үзэхээр энэ хүлэмжийн аж ахуй эрхлэлт дээр 2-оос 3 дахин дунджаар 2,5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байгаад байгаа юм. Тэгээд энэ үзүүлэлтүүдийг аваад үзэхээр дийлэнх гэдэг юм уу бараг 3 дахин нэмэгдсэн үзүүлэлт нь зуны хүлэмжийн аж ахуйн тариалалт дээр нэлээн нэмэгдсэн. Өвлийн хүлэмжийн тариалалт 2 дахин нэмэгдсэн байгаад байдаг. Зуны улиралд бид яг энэ хүлэмжийн аж ахуйг эрхлээд, зах зээлд нийлүүлэгдэж байгаа ногоо, өвлийн улиралд тариалж байгаа өвлийн хүлэмжийн өөрийнх нь өртөг зардал нэлээд өндөр байгаа учраас тодорхой асуудлууд гарч байна. Нэг талдаа.../минут дуусав/

Б.Бейсен: Жамбалцэрэн 5 номерт 1 минут сунгая, гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Хүнсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг бид нарын нэг гол анхаараад байгаа асуудал нь бүтээгдэхүүнийхээ гарц тал дээр нь илүүтэй анхаараад байдаг. Яг түрүүний Отгонбаяр гишүүний хэлсэн энэ дараагийн шаталсан арга хэмжээнүүдийг авах ийм шаардлага зайлшгүй байгаа. Ялангуяа энэ борлуулалт, түгээлтийнх нь энэ хаврын, зуны нийлэг, зуны хүлэмжийн тариалалтыг хийсэн даруйд нь бид борлуулалтынх нь тал дээр дэмжлэг үзүүлж явахгүй бол борлуулалт, энэ тээвэр логистикийнх нь асуудал, тэр талбай дээр зах зээл дээр нийлүүлэгдэж байгаа ногоон дээр нэг хүндрэлүүд гараад байгаа.

Хүнсний хөтөлбөрийн хүрээнд 3 ААН энэ хүнсний ногооны, ногоо боловсруулах савлах, ялангуяа энэ нарийн ногоон дээр зээлийн дэмжлэг авсан. Эд нар нь яг түрүүний Отгонбаяр гишүүний хэлсэнчлэн томоохон үйлдвэрүүд байгаад байгаа юм. Тэгэхээр өмнө нь өмнөх жилүүдэд бид энэ өрхийн тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр тодорхой дэмжлэгүүдийг үзүүлээд явж ирсэн. Тэгээд энэ нь яг нийт массын хэрэглээ дээр нийлүүлэлтэд тодорхой хувь хэмжээ үзүүлж чаддаггүй ийм нөхцөл байдал.../минут дуусав/

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар энэ Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын үндсэн зорилтод нь цаашид хүнс экспортлогч орон болно гэсэн байгаа юм байна. Тэгэхээр энэтэй холбоотой танай танилцуулгаас ер нь яг энэ экспортлогч орон болно гэдгийн дагуу ямар мэдээлэл танилцуулагдах нь вэ гээд нэлээн няхуур харж суулаа. Энэ дээр мах, махан бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ нэлээд өссөн дүр зураг сүүлийн хэсэгт танилцуулагдаж байна л даа. Ер нь энэ цаашдаа энэ 36 дугаар тогтоол хэрэгжээд 26 онд дуусахад зөвхөн махан бүтээгдэхүүн экспортлогч яг тийм орон болно гэдгээр төлөвлөж байна уу? Өөр бусад бүтээгдэхүүнүүдийг төлөвлөж байна уу? Яг энэ махны экспортын энэ 2022, 23, 24 оныг харьцуулсан график дээр харахаар 23 оноос даруй 10 гаруй хувиар бага хэмжээний махны экспортыг 24 оны гүйцэтгэлээр гаргасан юм байна.

Тэгэхээр энэ хууль, эрх зүйн орчны хүрээнд, янз бүрийн журмын хүрээнд хязгаарлалтгүй экспортын тоо хэмжээнд хязгаарлалтгүй байх чиглэлээр арга хэмжээ авсан хэр нь яагаад 24 онд махны экспорт буурсан юм бол? Ер нь 26 он гэхэд ямар дүр зургийг прогнозолж байгаа вэ? Махнаас гадна ямар бүтээгдэхүүн дээр төвлөрч ажиллаж байна вэ? Ер нь тэгээд бид яг энэ хүнс, хөнгөн үйлдвэрийн салбартаа төрийн оролцоо байх яг шаардлагатай юу, үгүй юу? Яг энэ 2 дээр хариулт авъя.

Б.Бейсен: 5 номер хариулья.

Т.Жамбалцэрэн: Уянга гишүүний асуултад хариулья. Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн өөрөө 5 зорилт бүхий 114 хэрэгжүүлэх арга хэмжээ байгаа. Тэгээд энэний эхний 2 хэсэг нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, энэ удирдлага бүтэц зохион байгуулалтыг сайжруулах чиглэлтэй. Нөгөө 3 нь яг энэ хүнсний боловсруулах үйлдвэр, мал аж ахуйн үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл гээд ингээд 3 чиглэлтэй байгаад байгаа юм. Тэгээд манай ХХААХҮ-ийн салбарт экспортын хамгийн боломжтой, илүү боломжтой салбар нь энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбар. Мал аж ахуйн салбарыг дагасан түүхий эдийн экспорт хамгийн боломжтой. Нөгөө талдаа газар тариалан дээр бид үр тариа, сэлгээний

таримал, тэр дотроо тэжээлийн ургамлын тариалалтууд, бусад энэ тосны ургамлын тариалалтуудын экспортыг нэмэгдүүлэх ийм боломж өндөр байгаад байгаа юм.

Нөгөө нөгөө талдаа экспортыг нэмэгдүүлэхэд гол хийгддэг ажил бол энэ олон улсын хорио цээрийн нөхцөл шаардлагуудыг импортлогч орнуудтай тохирдог. Эргээд бүтээгдэхүүн болгон дээрээ хорио цээрийн гэрчилгээнүүдийг тохирдог асуудал. Тэгэхээр энэ малын гаралтай бүтээгдэхүүн, ургамлын гаралтай бүтээгдэхүүн дээрээ бид олон улсын хорио цээрийн нөхцөл шаардлагад нийцсэн, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг хорио цээрийн нөхцөл шаардлагаар тохироод, зах зээлийг нь хувийн хэвшлүүдэд нээж өгөх ийм шаардлага байгаа. Бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоо харьцангуй бага. Татаас, дэмжлэг, урамшуулал хэлбэрээр төрийн оролцоотой. Экспортод гарах зах зээлийг нь нээж өгөх ийм л оролцоотой явж байгаа. Махны экспортын хувьд 17, 8 онд махны экспорт нэлээдгүй боломжийн явж ирсэн. 18, 19, 20 онд энэ ковидын цар тахлын нөлөөгөөр экспортод тодорхой хориг саадууд учирчихсан. Дийлэнхдээ манай мах, махан бүтээгдэхүүний экспорт 90-ээд хувь нь зөвхөн нэг импортлогч улсаас хамааралтай БНХАУ байгаа.

Бидний хувьд 10-аад оронтой хорио цээрийн нөхцөл тохирчихсон, гэрчилгээнүүд тохирох ажил хийгээд явж байгаа. Ойрх Дорнодод экспорт хийх ийм бололцоо бүрдчихсэн. ААН-үүд экспортоо хийгээд явж байна. Өнгөрсөн 23 оны 24, 23 оны жилийн эцсээр бид 80,1 мянган тонн махан бүтээгдэхүүн экспортолсон. Энэ оны жилийн эцсийн, 24 оны жилийн эцсийн тоогоор 70 гаруй мянган тонныг экспортолсон ийм үзүүлэлттэй байгаа. Энэ нь гадаад зах зээл дээр байгаа бид нарын эрэлтээс хамаарч байгаа. Нөгөө талдаа гадаад зах зээл дээр байгаа үнээс хамаарч байгаа. Цаашдаа бид энэ мах, махан бүтээгдэхүүний экспорт, ер нь энэ ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт дээр нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх, цаашдаа энэ гадаад худалдааныхаа асуудлыг энэ хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох дээр онцгой анхаарахгүй бол гадаад зах зээл дээр тодорхой асуудлууд үүсдэг.

Тодорхой зах зээл дээр энэ дотоодын компаниуд өөрсдөө өрсөлдөж, үнээ унагадаг энэ асуудлууд байгаа. Ялангуяа бид мах, махан бүтээгдэхүүн дээр нэг цонхны бодлогыг хэрэгжүүлээд мах, махан бүтээгдэхүүнийг экспортлогч ААН-үүд зөвхөн төрөөс гэдэг юм уу, төрийн бус байгууллагуудаас холбогдох Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас гарал үүслээ авна, лабораториудаас шинжилгээний бичиг авна, стандартаас тодорхойлолт авна, гаалийн бүрдүүлэлт хийнэ гээд ингээд 1-2 сарын хугацаа авдаг байсан энэ асуудлуудыг бид хөнгөвчлөөд 7 хоногт багтаад хийх, тэгээд цахим үйлчилгээнүүдийг нэвтрүүлсний үр дүнд тодорхой ахиц гарсан.

Дээр нь тодорхой бүтээгдэхүүнүүд дээр тоо хэмжээг хязгаарлалт тогтоодог байсан. Тэгээд ямар нэгэн нэр төрөл дээр хязгаарлалт тогтоодоггүй болсонтой холбоотой, нэг цонхны үйлчилгээ хэрэгжүүлсэнтэй холбоотой экспорт маань нэлээн ахицтай гарсан. Бидний нэг гол анхаарах асуудал энэ үнийн асуудал, тэр тарифын асуудал. Эргээд энэ ургамлын гаралтай бүтээгдэхүүн дээр тосны ургамал экспорт харьцангуй тогтвортой явагдаж байна. Тосны ургамал дээр яг энэ үнийн асуудал үүсэж байгаа юм. Тийм учраас энэ аль, аль бүтээгдэхүүн дээр нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, дотооддоо энэ худалдааны тарифын зохицуулалтуудыг хийж, үнэ унагахгүй байх, дотооддоо харьцангуй.../минут дуусав/

Б.Бейсен: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс олон сайхан санаачилгуудыг гаргаад, амжилттай хэрэгжээд явж байгаа. Эрүүл Монгол хүн, Цагаан алт, Хүнсний хувьсгал, Тэрбум мод гээд. Үүний нэг нь энэ хүнсний хувьсгал байгаа. Үүний зорилго тодорхой. Өөрсдөө Монгол Улс өөрөө хүнсээ дотоодоосоо хангая, илүү гарснаа экспортолъя л гэсэн гол зорилго шүү дээ. Тэгээд миний гол ярих гэж байгаа зүйл үүнтэй холбогдуулаад 36 дугаар тогтоол дээр аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээнүүд ав гэсэн. Хүнсний аюулгүй байдал. Хүнсний хувьсгал арга хэмжээний явц тогтоолын хэрэгжилт 61,8 хувь гээд олон ажлуудыг хийж байгааг мэдэж байгаа.

Үүний хажуугаар аюулгүй байдал дээр хэрхэн хяналт тавьж байна вэ, хүнсний аюулгүй байдал ямар хэмжээнд байна гэдэг их чухал асуудал шүү. Тэгэхээр энэ та бүхний хэлж байгаа мэдээлэл дээрээс энэ талаар их бага мэдээлэл тусгагдсан юм болов уу гэж харж байгаа. Шадар сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу энэ хүнсний зах, худалдааны төвүүдээр зөвхөн жимс, хүнсний ногоон дээр хийсэн хяналт шалгалтаар 44 төрлийн пестицид илэрлээ гэсэн ийм мэдээлэл авсан. Мөн сүүлийн үед хил боомтоор эрүүл ахуйн шаардлага хангахгүй импортын хүнсний бүтээгдэхүүнүүд их хэмжээгээр орж ирж байгаа. Ялангуяа уул уурхайтай аймгуудад энэ олон хүн төвлөрсөн ийм газруудад хүнсний аюулгүй байдал, мөн хоол хүнстэй холбоотой өвчин, халдварт өвчин гарах явдал сүүлийн үед ажиглагдаад байгаа. Энэ дээр хяналт шалгалтыг хэрхэн хийж байгаа вэ? Мэргэжлийн хяналтын ерөнхий газар гэж байхад хяналт шалгалтыг иж бүрнээр нь сайн нэгдсэн удирдлага, удирдамжаар зохион байгуулж хийдэг байсан. Үүнийг татан буулгачихсанаас хойш хяналт шалгалтыг хэрхэн яаж зохион байгуулж байна вэ, хэр үр дүнтэй энэ хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулж байгаа вэ?

Мэргэжлийн хяналтыг татан буулгачихсанаас хойш яамнуудад хяналтууд очсон. Ингээд үүнээс хойш тойрогт ажиллаж байхад ААН, иргэдтэй уулзаж байхад хяналт шалгалт маш их давхардаж байна. Нэг шалгалт ирээд явахад, маргааш нь дараагийнх нь хүрч ирээд ингээд явж байна. Хуучин бол давхардал байдаггүй иж бүрнээрээ хүрч ирээд явдаг байсан. Одоогийн нөхцөлд хяналт шалгалт суларсан. Ялангуяа орон нутагт мэргэжилтэн байхгүй, боловсон хүчин байхгүй. Хүнс, хөдөө аж ахуйн газар 2 байцаагчтай, сумдуудад байхгүй, сумдад байцаагч хэрэгтэй. Ийм мэргэжилтэн байхгүйгээс болоод.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Хариултын дотор, 5 номер хариулья.

Т.Жамбалцэрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулья. Хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой 36 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 114 хэрэгжүүлэх арга хэмжээ байгаа. Түүний 90 орчим нь цэвэр ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа үйл ажиллагаанууд байгаа. Бусад нь үлдэж байгаа хэсгүүд нь салбар хоорондын уялдаатай ийм агуулгууд байгаа. Ялангуяа энэ Эрүүл мэндийн яамны оролцох асуудал Байгаль орчны яам, Зам, тээвэр хөгжлийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам гэдэг юм уу. Тэгээд ингээд салбар хоорондын уялдааг хангах асуудал энэ хүнсний хөтөлбөрийн хэрэгжилт дээр нэлээн тулгамдаж байгаа юм. Тэгээд энэ чиглэлээр энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аудитын байгууллага, манай яам, бусад төрийн оролцогч байгууллагууд хяналт шалгалтын чиг үүрэгтэй байгууллагуудыг оролцоод үндэсний хэмжээнд хяналт шалгалт зохион байгуулах, үр дүнгийн хэрэгжилтэд тодорхой аудит хийхээр ингээд ажиллаж байгаа.

Энэ хүнсний аюулгүй байдлыг хангуулж байгаа энэ бүрэлдэхүүн хэсэг дээр асуудлууд байгаа. Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж, чиг үүргүүд нь салбарын яамдад ирсэнтэй холбоотой хүнсний аюулгүй байдалтай холбоотой хяналтын асуудлуудыг яамны бүтцийн нэгжээр Салбарын хяналтын газар гээд хяналт шалгалтыг хийгээд явж байгаа. Аймаг болгоны Хүнс, хөдөө аж ахуйн газар дээр салбарын хяналтын 4 байцаагч ажиллаж байгаа. Тэгээд тэдний маань хүрч ажиллах боломж бололцоо тун хангалтгүй байгаад байгаа. Тэдний орон нутагт ажиллах томилолт, урсгал зардлууд маань нэлээн тулгамдчихсан. Дээр нь яг таны хэлсэнчлэн энэ салбар хоорондын уялдаа холбоо багатайгаас хяналт шалгалтууд давхардаж байгаа асуудлууд байгаад байдаг.

Манайд зөвхөн мал эмнэлгийн хяналтууд, тэгээд худалдааны хяналтууд, боловсруулах үйлдвэр дээр технологийн хяналтууд явагдаад байдаг. Хүнсний эрүүл ахуйн хяналт нь Эрүүл мэндийн яам дээр явж байна гэдэг юм уу. Тэр дагадаг бусад стандарттай холбоотой, тэр барилга байгууламжтай холбоотой гэдэг юм уу энэ хяналтууд нь бусад салбарууд дээрээ гээд. Байгаль орчны хяналт нь гэдэг юм уу, хүүхдийн хоолны хяналт гэдэг юм уу эд нар нь өөрсдөө ингээд салангид болчихсон учраас яг иргэн, ААН дээр орж ирж байгаа хяналт шалгалтын үйл ажиллагаанууд нь давхардсан байдал нийтээрээ байгаад байгаа. Сум дээр очоод хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг хянаж байгаа мэргэжилтэн улсын байцаагч байна уу гэхэд одоогийн бүтцээр байхгүй байгаад байгаа юм. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа 4, 5 байцаагч л тухайн аймаг орон нутгууд дээр, сумдууд дээрээ очиж хүрч ажиллаж байгаа. Тэгээд тэд нарын ажлын ачааллыг аваад үзэхэд харилцан адилгүй. Зарим томоохон Өмнөговь аймгийн Ханбогд сум гээд л тэгэхэд хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангуулж байгаа хүн тэнд одоогоор байхгүй байх жишээтэй. 1 аймгаас том хүн амтай, хяналт шалгалтын объект нь төдий хэмжээгээр олон ийм сум байх жишээтэй.

Тэгэхээр хяналт шалгалтын удирдамжийг батлаад, хэрэгжүүлээд явахад сум дээр байгаа 4 байцаагч тухайн 18 сумтай, 20 сумтай гээд ингээд аваад байдаг жилдээ 4, 5 сумыг л ингээд л нэгдсэн удирдамжаар хяналт шалгалт хийдэг. Бусдад нь хяналт шалгалтад хамрагдаж чаддаггүй нөхцөл байдалтай. ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд энэ 21 аймаг дээр байгаа ХАА-н газрын байцаагчид, 330 сумд байгаа мал эмнэлгийн тасаг, хөдөө аж ахуйн тасгууд дээр бид улсын байцаагчийн эрхийг олгуулах асуудал, тодорхой мэргэжилтэй ажилтан ажиллуулах асуудал дээр бид зохион байгуулалтын арга хэмжээг авахаар ажиллаж байна. Дээр нь яг таны хэлсэнчлэн орон нутаг дээр мэргэжилтэй боловсон хүчний дутагдал үнэхээр их байгаа. Энэ хүнсний хангамж, аюулгүй байдлын 36 дугаар тогтоолын хүрээнд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ шаардлагатай мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр тодорхой агуулгууд тусгагдчихсан. Энэ чиглэлээр тодорхой төсөв зардлууд суугдсан хэдий ч тодорхой үр дүнд хүрээгүй асуудлууд байгаад байгаа. Тэгээд энэ дээр цаашдаа бид анхаарах зайлшгүй шаардлага байгаа гэдгийг танилцуулгаа.../минут дуусав/

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр ер нь хүнсний аюулгүй байдал гэдэг чухал шүү. Яг үнэндээ бодит байдал дээр бид эрүүл хүнс идэж байгаа эсэхээ мэдэхгүй байгаа шүү. Ялангуяа хөдөө орон нутагт хяналт шалгалт байхгүй байгаа шүү. Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлж байгааг би сонсож байсан. Мэргэжлийн хяналтыг дахиж байгуулах шаардлагатай гэдэг дээр би санал нэг байдаг хүн. Хөдөө

орон нутагт ажиллаж байсан хүний хувьд энэ хүнд асуудал шүү гэдгийг хэлье. Энэ дээр цаашдаа анхаараарай.

Дээрээс нь нэг тодруулж энэ нөгөө хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлүүд ингээд хангайн бүс, төвийн бүс гээд, зүүн бүсэд олгогдоод нэлээн хэдэн үйлдвэрүүд бий болсон юм байна. Тэгээд тайлан дээрээс харж байхад говийн бүсэд зээл олгогдож, үйлдвэрлэл явуулж байгаа зүйл тайлан нь байхгүй байх юм. Энийг нэг тодруулаадхаач.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Энэ сая танилцуулга дээр гарсан нь 39 үйлдвэр гээд шинээр байгуулагдсан гээд. Энэ шинээр байгуулаад ашиглалтад орчихсон үйлдвэрүүдийнх нь үзүүлэлтүүдийг гаргасан юм. Зээл олгоод энэ чинь 1 жил, 1,5 жил өнгөрч байгаа. Тэгээд зээлийн үр дүнгүүд нь хэрэгжээд явж байгаа төсөл, хөтөлбөрүүд байгаа. Яг говийн бүс дээр гээд ААН-үүдийн зээл авсан дүнгээр нь аж ахуй нэгжийнх нь жагсаалтаар нь албан тоот бичгээр танд хүргүүлъя. Энэ үр дүнгүүд нь гарчихсан байгаа. Дээр нь энэ сая танилцуулга дээр гардаг нь ХХААХҮЯ-тай хяналтын гэрээ байгуулсан том зээлийн дүнтэй ААН-үүдийн мэдээлэл орсон байгаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Энэ төсөл, хөтөлбөрүүд, зээл говийн бүс рүү их бага хуваарилагддаг. Хэзээнээсээ нэг ийм үзүүлэлт статистик гараад байдаг. Тэгээд тойрогт ажиллахаар говийн бүсэд чинь хамгийн их боломж байгаа том, том уул уурхай, түүнийг дагасан хүн амын нягтаршил, тэгээд л хоол хүнсний хэрэгцээ гээд. Тэгээд үйлдвэрлэл эрхлэгчид маань ярьдаг нэг зовлон бол тэр хөнгөлөлттэй, бага хүүтэй зээл үйлдвэрлэл, ЖДҮ дэмжих энэ зээлүүд наашаа ерөөсөө бага байх юм гэдэг. Тэнд хамгийн их хэрэгцээ байгаад байгаа мөртөө энэ үйлдвэрлэл эрхлэх гэхээр зээлүүд нь ерөөсөө олдохгүй байна гэдэг асуудлыг тойргийн иргэдтэй уулзаж байхад ярьдаг.

Нөгөө талаасаа уул уурхайн компаниудтай уулзахаар бид аль болохоор энэ орон нутгийн иргэдээ дэмжээд, хүнсний бүтээгдэхүүн, мах, сүүг нь авмаар байдаг. Гэтэл эд нар маань шаардлага хангасан үйлдвэрлэл хийж чадахгүй байна, тоног төхөөрөмж байхгүй байна. Зээл.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Наранбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Үндсэндээ сая танилцуулгаар 1,2 их наяд төгрөгийн зээл гарсан гэж танилцуулсан. Тэгээд энэ нь нийтдээ нэг зээл хүсэгчдийн 50 хувьд нь очсон л ийм зээлийн дүн байгаа. Цаашид нь мөн энэ хэмжээний эрэлт хэрэгцээ байгаа гэж ингэж үзэж болно. Тэгээд цаашдаа бид зээлийг үр дүнтэй болгох, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дахиж нэмэлт үүсвэр шаардлагатай болно гэж ингэж үзэж байгаа.

Дээр нь Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдтэй хэлэлцээрийн хүрээнд хийгдэж байгаа зээлийн төслүүдийг хамруулж ингэж тооцож байгаа юм. Зээлийг хэрэгжүүлэхдээ бид арилжааны 10 банктай гэрээ байгуулсан. Цэвэр бизнес эрхэлж байгаа иргэн, ААН-үүдийн хүсэлт дээр тулгуурлаж байгаа. Зээл авсан иргэн, ААН-үүд арилжааны банкнуудад нь бид хүүгийн хөнгөлөлтийг нь олгоод явж байгаа

ийм хэлбэр. Тэрнээс ямар нэгэн аймаг, сумаар нь гэдэг юм уу, тодорхой хувь хэмжээ тогтоосон асуудал байхгүй. ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2 зээлийн төсөл үйл ажиллагаа.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Тэдгээр төслүүд дээр ХХААХҮ-ийн сайдын тушаал гаргаад, аль болох орон нутагт, энэ орон нутгийн энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр тулгуурлаад хөдөөгийн хөгжлийг дэмжих чиглэлээр, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд нийт төслийн санхүүжилтийн 70 хувийг нь орон нутагт зарцуул гэдэг ийм сайдын тушаал гаргаад, чиглэлүүд хүргэгдчихсэн. Энэ хүрээндээ олгогдоод явж байгаа. Ялангуяа энэ жижиг, дунд бизнесийн зээлүүд.

Б.Бейсен: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: 1 дүгээрт яам чинь нүүсэн, Дархан руу очсон. Үйл ажиллагаа чинь жигдрээд сайхан болж байгаа юм болов уу л гэж бодоод байгаа шүү дээ. Тийшээ мэдээж нүүсэн юм чинь. Та хэд маань хэзээ яам, өчигдөр нэг дэх өдөр яаман дээрээ байсан уу, байгаагүй юу? Өнөөдөр өглөө үүрээр гарсан юм уу, яасан юм бэ, хэзээ ирсэн юм бэ? Эсвэл өнөөдөр яам руугаа оройдoo гарах юм уу, маргааш очих юм уу нэг ийм нэг сонирхолтой асуудал байна 1.

2 дугаарт энэ 36 дугаар тогтоолыг та бүхэн мэдэж байгаа. Миний бие нөгөө ажлын хэсгийг нь ахлаад явсан шүү дээ. Бидний зорилго хүнсний хувьсгал хийгээд, хүнсний үйлдвэрлэлээ нэмэгдүүлээд, өргөжүүлээд, одоо байгааг нь улам сайжруулаад, хөл дээрээ босож чадаагүйг нь хөл дээр нь босгоод, тэгээд өргөжүүлье гэж байгаа юм, өргөжүүлье гэсэн ийм том зорилт тавьсан, өргөжүүлье. Ер нь хүнсний хангамж хангалтгүй байгаа шүү дээ. Хангалтгүй байгаа. Энийг Монгол Улсын Ерөнхийлөгч олж хараад маш зөв зүйтэй шийдвэр гаргаад, 1,5 их наяд байх аа, төгрөгийн ийм зээл, тусламж, санхүүжилтийг гаргая гээд шийдвэр гаргаад ингээд явсан. Тэгээд үүнээс 1,2 их наяд гарсан юм байна. 3153 ААН байгаа юм байна. Хэдэн ААН шинээр гарсан бэ? Хэдэн ААН шинээр байгуулагдсан бэ? Хүнс үйлдвэрлэл рүү орсон бэ? Алхаж орсон бэ 1?

2 дугаарт 1,2 их наяд төгрөгийн хэдэн хувь нь гэх юм уу, юу гэх юм нөгөө ААН-үүдэд дэмжлэг үзүүлээд хөл дээр нь босгох, өөрөөр хэлбэл хуучин ААН-үүдийг сайжруулах, технологийг нь сайжруулах, үйлдвэрлэлийг нь нэмэгдүүлэхэд зарцуулсан, хэдэн төгрөг зарцуулсан, 1 ААН дээр хамгийн максимал нь хэдэн төгрөг очсон бэ? Дээрээс нь шинэ ААН-үүдэд ер нь хэдий хэмжээний мөнгөн нийт 1,2-ын чинь хэдэн хувь нь очсон юм? Тэгээд 1 ААН-д дунджаар хэдэн төгрөгийн ийм санхүүжилт очсон юм бэ? Тэгээд 3 дахь, 4 дэхэд нь энэ нөгөө бидний хүнсний хангамж маань их олон тоо л гарчхаад байна л даа. Ер нь дунджаар хэдэн хувь өссөн юм бэ гэсэн нэг ийм л хэдэн тоо л сонирхоод байна. Баярлалаа.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн дарга 5 номер.

Т.Жамбалцэрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын шийдвэр, Засгийн газрын шийдвэртэй холбоотой ХХААХҮЯ Дархан-Уул аймагт шилжин ажиллаж байгаа. ХХААХҮ-ийн сайдын тушаал гаргаад нийт албан хаагчдын 70 орчим хувь нь Дархан-Уул аймагт шилжин ажиллаж байна. 30 хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байгаа. Албан хаагчдын нийгмийн асуудал, орон сууц,

нийгмийн асуудал шийдвэрлэгдсэний дараа яам 100 хувь Дархан-Уул аймагт шилжиж ажиллана. Өнөөдрийн байдлаар Дархан-Уул аймагт 70 хувь нь, Улаанбаатар хотод 30 хувь нь ажиллаж байна.

Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хэрэгжилттэй холбоотой 1,2 их наяд төгрөгийн зээл гарсан. 3000 гаруй ААН-үүдэд зээл хүрч байгаа. Арилжааны 10 банктай гэрээ байгуулаад эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлүүд, дийлэнх нь ерөөсөө хуучин үйл ажиллагаа явуулж байсан ийм ААН-үүд байгаа. Тэдний технологийн шинэчлэл, өргөтгөл шинэчлэлийн ажлууд дээр зарцуулагдаад явж байгаа. Үнийг нь зээлийн хэмжээнээсээ хамаараад ХХААХҮЯ бодлогын гэрээ байгуулаад, бодлогын гэрээнийхээ дагуу төслийн хэрэгжүүлэх зээлийн хэрэгжилтэд нь хяналт тавиад ажиллаж байгаа. Үнийн дүн багатай хэсгийн аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг нь гаргаад орон нутгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулаад хяналтыг тавьж ажиллаж байгаа. Зээлийн дүнгээр нь Довчинсүрэн дарга задлаад танилцуулчих.

Б.Бейсен: 4 номер хариулья.

Д.Довчинсүрэн: Нийт энэ хүсэлт гаргасан 2,2 их наяд төгрөгийн хүсэлтийг ААН-үүд гаргасан байгаа. Тэгээд зээлийн шийдвэрлэлт нь нийтдээ 55 хувь нь шийдвэрлэлт хийгдсэн. Зээлийн эх үүсвэрийн ашиглалт нь 98 хувьтай байгаа. Энэ нь 1,2 тэрбум төгрөгийнхөө эх үүсвэрийн 98 хувийг нь ашигласан байгаа. Мөн эргэлтийн хөрөнгийн зээлийг газар тариалангийн үйлдвэрлэл 100 хувиар, хүнсний үйлдвэрлэл 100 гаруй хувиар, мал аж ахуйн үйлдвэрлэл 81 хувиар, хөрөнгө оруулалтын зээлийг газар тариалан 85 хувь, хүнсний үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэл бол 79 хувийг, мал аж ахуйн үйлдвэрлэл 43 хувьтай байгаа. Олгосон зээлийн хэмжээгээр нь газар тариалангийн чиглэлээр 344 тэрбум төгрөг, хүнсний чиглэлээр 812 тэрбум төгрөг, мал аж ахуйн чиглэлээр 102 тэрбум буюу 8 хувийг нь эзэлсэн ийм дүнтэй байгаад байгаа юм.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулья.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ бүр тодорхой нэг зүйл асуухад сүүний үйлдвэрлэл яг бид нарын сүүн нийлүүлэлтийн хэдэн хувийг дотоодоосоо нийлүүлж байгаа вэ? Сүүлийн, хэд байснаа хэд болсон бэ 1?

2 дугаарт нөгөө сүүний энэ хэн сайн мэдэж байгаа даа. Фермерүүдээ тоог нь нэмэгдүүлье гэсэн. Сүүний үйлдвэрлэлийн тийм хүчин чадлыг нь нэмэгдүүлэхэд үхрийнхээ тоог нэмье гэсэн шүү дээ. Сайн чанарын үхрийг нэмье гэсэн. Тэгээд тэр тэжээлийн үйлдвэрүүдийг нэмэгдүүлье гэсэн. Дараа нь тэжээлийн үйлдвэрийн газар олголтыг нэмэгдүүлье гэсэн. Ингээд цаашаа, цаашаа яваад, бүхэлд нь энэ асуудлыг шийдье гэсэн шүү дээ. Энэ жишээ нь шийдэгдсэн үү? Хэдэн хувийн сүү нийлүүлэлттэй болсон юм бэ, хэдэн үхэр үйлдвэрлэлд орж ирж байгаа юм бэ? Энэний үржлийн асуудлуудыг нь яаж шийдэж байгаа юм бэ? Нөгөө аманд нь.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулья.

Д.Довчинсүрэн: Сүүний үйлдвэрлэлийн салбар 2022 онд 212 сая литр сүүг хөдөө аж ахуйгаас бэлдэж яг үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн сүү бол 45,9 сая литр байсан. 2000, шингэн сүүнийхээ 99 хувийг, сүүн бүтээгдэхүүнийхээ 57 хувийг нь хангаж байгаа дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа. 2024 онд болохоор 104,

148,6 сая литрийг хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн. Үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн 59,6 сая литрийг үйлдвэрлэж байгаа. Энэ дээрээ холбогдуулаад манай яамнаас сүүний урамшууллын мөнгөн дүнг яг энэ 36 дугаар тогтоолынхоо хүрээнд 500 төгрөг байсныг 1000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Энэ хүрээндээ яг энэ.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя.

Д.Довчинсүрэн: Улаанбаатар хотыг тойрсон 3 аймаг л бэлтгэн нийлүүлэлт хийгддэг байсан бол энэ жилийн хувьд 12 аймаг болж нэлээн тоо нь өсөж явсан. 10 мянга гаруй малчин эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч маань яг энэ сүүний урамшуулалт бол хамрагдаад нэлээн энэ яг 11 сарын 1-нээс 3 сарыг дуусталх хугацаа буюу хүйтний улирлын энэ шингэн сүүний нийлүүлэлт нэлээн нэмэгдсэн дүр зураг байгаа.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын төрийн тэргүүн хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөнийг өрнүүлээд хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний том төлөвлөгөө хөтөлбөрийг Их Хурлаас батлаад, хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Үр дүн би гайгүй явж байна гэж хардаг. Гэхдээ бидэнд бодохоор юмнууд байгаад байна. Энэ хөдөө аж ахуйн салбар, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг хангана гэвэл энэ салбарын суурь эрх зүйн орчныг бид том зургаар нь харж, бүрдүүлэх тухай л асуудал байгаад байгаа юм. Тийм учраас тэр хөдөө аж ахуйн салбарын, хөнгөн үйлдвэрийн, хүнсний гэсэн 3 том хууль орж ирж байж энэ салбар буйдаа харилцан уялдаатай хөгжих тийм боломж нь бүрдэх болов уу гэж хараад байгаа юм. Энэ эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар ер нь юу бодож, юу хийж байна вэ? Үр дүн ямар түвшинд явна вэ гэж нэг ийм зүйл?

2 дахь зүйл. Хүнсний хэрэглээний асуудал дээр нэр төрөл маш өргөн болсон юм билээ. Гэхдээ туурга тусгаар улс үндэстэн байна хамгийн гол гэж яригдах 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг нь дотроо дотоодоосоо хангая гээд хэдүүлээ зорилт тавьсан. Энэ 19 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ зорилтот түвшиндээ хүрэхэд ер нь юу болж байгаа вэ? Ирэх жил энэ том төлөвлөгөөний чинь сүүлийн жил байгаад байгаа. Зарим зүйлүүд хангагдаж байгаа, хангагдаж байгаагаараа хэдүүлээ тооцоод явж боломгүй. Ургамлын тос гэхэд бидний суурилагдсан үйлдвэр тарьж байгаа үр 2 зөрөөд болж өгөхгүй байгаа. Сахрын тухай ярьдаг. Өнөө чихрийн манжингийн асуудал юу болж байгаа вэ гээд бидэнд бодохоор юмнууд байгаа. Үүнийгээ хэдүүлээ яаж энэ 24, 25, 26 онуудад урагш нь ахиулах вэ, бодлогоо энэ рүү чиглүүлэх вэ гэдэг асуудал байна. Энэ дээр ямар бодол, юу байна вэ гэж?

3 дахь зүйл Малын тэжээл, гурилын импортын гаалийн албан татварыг тэглэсэн. Ихээхэн сүр дуулиантай юм болсон. Үр дүн, үр дагавар нь юу болов? Би тариалалт үйлдвэрлэлээ 20 гаруй хувиар бууруулж унагаж чадлаа. Үнийн бууралт чинь хүсэн хүлээсэн хэмжээнд очсонгүй. Улсын Их Хурлаас нэг ажлын хэсэг ажиллаж байгаа. Асуудлаа хариуцаж байгаа салбарын яамны хувьд томоохон дүгнэлт хийсэн байх. Үүн дээр ер нь ямар зохицуулалт хийнэ гэж бодож байна вэ? 25 оны хаврын тариалалт хаяанд ирлээ. Энэ тариаланч түмэн олныг хэдүүлээ нэг итгэл төгс тариалалтаа хийх тэр нөхцөлийг нь бүрдүүлж өгөх юм сан даа. Энэ дээр ямар шийдэл байна нөхөд өө? Юу болж байна гэдэг нэг ийм.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн хариулъя.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зорилготой Цагаан алт хөтөлбөрүүд маш өндөр хүлээлттэй салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд, нийгэм, эдийн засгийн амьдралд тодорхой өндөр хувь нэмэр оруулна гэсэн ийм хүлээлттэй байгаа. Дээр нь шинэ хоршоо, чинээлэг малчин хөтөлбөр. Салбарын яамнаас Атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлнэ гээд ойрын хугацаанд ЗГ-аар хэлэлцүүлээд Улсын Их Хуралд танилцуулахаар хөтөлбөрийг төлөвлөж байгаа. Энэ 4 хөтөлбөр харилцан уялдаатай, нэг нэгнийгээ харилцан шүтэлцээтэй ийм хөтөлбөрүүд байгаа.

Түрүүний Батжаргал гишүүний, Бат-Эрдэнэ гишүүний асуусан тэр тариалангийн талбайг 200 мянган га-гаар нэмэгдүүлэх, дээр нь энэ 200 мянган га-гаа илүүтэй тэжээлийн ургамал тариалалт руу шилжүүлэх гээд тодорхой ажлууд хийгдэж байгаа. Газрынхаа суурь асуудлаа шийдэж байж бид энэ дээрээ тариалангийнхаа төрөл, сэлгээний ургамал, сэлгээний тариалалт, дээр нь энэ малынхаа тэжээлийг бэлдэх гээд энэ цогц бодлого хэрэгжих ёстой. Эдгээр бодлогуудыг хэрэгжүүлэхэд салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага байгаа. Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Ойрын хугацаанд ЗГ-аар хэлэлцүүлээд, холбогдох Байнгын хороогоороо хэлэлцүүлээд ингээд явна.

Хүнсний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар холбогдох Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох боловсруулалтыг хийгээд бэлэн болсон байгаа. Мөн ЗГ-аар хэлэлцүүлээд ойрын хугацаанд Улсын Их Хуралд өргөн барихаар ингэж төлөвлөж байгаа. Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн дээр тусгагдсан 100 хувь импортын хамааралтай бүтээгдэхүүнүүд байгаа. Энэ дотроо ургамлын тос, элсэн чихэр, цагаан будаа гээд эдгээр бүтээгдэхүүнүүд дээр тодорхой арга хэмжээ авахаар дотоодод байгаа энэ суурилагдсан хүчин чадалтай тос боловсруулах үйлдвэрийнхээ хүчин чадал дээр тулгуулаад таримлынх нь асуудал дээр тодорхой ахиц гаргая гээд энэ чиглэлийн таримал тарьдаг ААН-үүдтэй уулзаад, тодорхой шийдэлд хүрээд ажиллаж байгаа. Энэ хавраас төлөвлөгөөт тариалалтыг хийж энэ тосныхоо үйлдвэрийг дотоодынхоо түүхий эдээр бүрэн хангах энэ ажлыг эхлүүлж ажиллана.

Сахар боловсруулах үйлдвэртэй холбоотой ТЭЗҮ-ийг боловсруулаад, гаднын хөрөнгө оруулалтаар хийх чиглэлээр салбарын яам болон ХААЯ-ны дэргэдэх Хөдөө аж ахуйн корпорацитайгаа хамтраад ажиллаж байна. Гаднын хөрөнгө оруулагчтай нийлээд ТЭЗҮ, судалгааныхаа ажлуудыг хийгээд дуусаж байгаа гэдгийг хэлье.

Гурилын гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуультай холбоотой үр дүнгүүд байгаа. Энэ хууль хэрэгжсэн хэрэгжсэнээр нийтдээ 64 аравны мянган тонн улаан буудайн буюу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоор 35,9 мянган тонн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14,1 мянган тонн гэдэг юм уу, нийтдээ 64,2 мянган тонн улаан буудайн гурилыг ОХУ-аас импортоор авсан ийм дүн байгаа. Мөн 24 оны жилийн эцсээр 17,9 мянган тонн буюу өмнөх үетэй харьцуулахад нэг дахин их тэжээлийг импортоор авсан байгаа. Тэгээд энэ үзүүлэлт маань стратегийн хүнс болох улаан буудайн болон гурилын үйлдвэр, нийлүүлэлтийн сүлжээнд нэлээдгүй энэ доголдлыг бий болгосон. Тэгээд энэ чиглэлээр салбарынхаа тариаланчидтай, гурил үйлдвэрлэгч ААН-үүдтэй тодорхой уулзалтуудыг хийсэн. Гурилын үнэ өөрөө зах зээл дээр тогтворжсон уу гэдэг дээр авч үзэхээр дүгнэлтүүд байгаа. Гурилын

үнэ буурсан үзүүлэлт байхгүй, импортын гурил л нэмэгдсэн ийм үзүүлэлттэй байгаа. Тэгээд салбарын яамнаас.../минут дуусав/

Б.Бейсен: Жамбалцэрэн дарга гүйцээж хариулъя, 6 номер гүйцээж яриулъя. Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгээд яах вэ өнгөрсөн жилийн нөхцөл байдалтай холбоотойгоор гурилын гаалийн албан татварыг тэглэх тухай энэ хууль батлагдаж, үр дүнгээ тодорхой хэмжээнд өгч, эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулсан хэдий боловч яг газар тариалангийн салбартаа нэлээн хүндхэн цохилтыг өгөөд байгаа. Тухайлбал улаан буудайн тариалалт 35,7 мянган га-гаар буурсан, нийт ургац 57 мянган га-гаар буурсан ийм үзүүлэлт байгаад байгаа, байгаад гарч ирж байгаа.

Түүнчлэн энэ зөвхөн газар тариалангийн салбар гэдэг хэдэн тариаланчдын асуудал биш. Тариалангийн салбарт энэ үйл ажиллагаа явуулж байгаа техник, тоног төхөөрөмж нийлүүлдэг ААН-үүд, ургамал хамгааллын бодис, бордоо нийлүүлдэг ААН-үүдээс авсан ийм энэ бүтээгдэхүүнийхээ төлбөрийг төлж чадахгүй нөхцөл үүсээд ингээд ер нь салбар ингээд сүлжээгээрээ доголдох ийм асуудал үүсчхээд байгаа учраас энэ дээр тооцоо судалгааг гаргасан. Тэгээд Оросын.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя, Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Тийм учраас энэ салбарыг тухайн үед гарсан гаалийн импортын гаалийн албан татварыг тэглэх тухай хуулийг хүчингүй болгох энэ хуулийг бид сая ЗГ-ын хуралдаанд танилцуулаад юу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шийдвэр гаргасан. Энийг хугацааг нь ингээд дуусгавар болгох, хүчингүй болгох ийм хуулийн төслийг барьж байгаа. Тэгээд энийг энэ арга хэмжээг ингэж хэрэгжүүлэхгүй бол салбар бүхэлдээ доголдох ийм асуудлууд гараад байгаа. Тэгээд дээрээс нь ОХУ-аас орж ирж байгаа гурил үнийн хувьд төдийлөн бууралт өгөөгүй. Тэгээд орж ирж байгаа гурил нь 2 янзын чанартай байгаад байгаа. Дийлэнх нь ерөнхийдөө гост буюу улсын стандартыг хангаж байгаа гурил байгаа нь үйлдвэрлэлд нийцэж байгаа боловч манай ААН-үүдийн оруулж ирж байгаа гурил тэгээд техникийн нөхцөл буюу ТУ стандарт гээд энэ стандарт биш техникийн нөхцөл хангаж байгаа гурил оруулж ирж байгаа нь бол бид нарын нөгөө хүрсэн хүнсний аюулгүй байдал, дотоодын гурилын.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ нэг иймэрхүү урьдчилсан дүн харагдаад байна уу гэж бодоод байдаг юм. Тэгэхээр одоо хэдүүлээ их бодитой юм яримаар байгаа юм. Хаврын тариалалтад чинь 13 орчим мянган тонн үр тариа дээр үрийн дутагдал үүсэх нь үү? Төмсний үрийн шинэчлэл чинь нэлээн хоцрогдолтой явна уу гэж ингэж харагдаад байгаа. Үүнийг хангах талаар ер нь ямар бодлого байна вэ? Энэ чинь ерөөсөө угаасаа бид хэдийн яриад байгаа энэ хүнсний хангамжийн чинь зорилтот түвшнийг хангахад хамгийн гол үүрэг. Ер нь тэр Атрын 4 дүгээр аяны том хөтөлбөр хаана явна вэ? Ямар бодлогууд тусав? Түүн дотор энэ үрийн аж ахуйнуудынхаа хөгжлийг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд нь олгох урамшууллын асуудлыг ер нь юу гэж тооцож яваа вэ? Бид ерөөсөө таваарын бүтээгдэхүүнээ урамшуулалтай дэмжээд явсан болохоос биш өнөөхийг бүрдүүлдэг үрийн аж ахуйнхаа хөгжлийн асуудлыг орхигдуулсан улс юм билээ. Энэнээс болоод энэ салбарт.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн 1 минут нэмж олгоё.

Ж.Батжаргал: Доголдлуудыг бий болгосон юм болов уу гэж. 2 дахь зүйл Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа ямархуу байна вэ? Энэ шинэ хоршоотойгоо хэрхэн хоорондоо угсрагдаж байгаа вэ? Цаашид энэ хөнгөн хүнсний үйлдвэрүүдтэйгээ яаж угсрагдах юм бэ бирж чинь? Энэ бидний энэ тавиад байгаа зорилтод их том үүрэг гүйцэтгэнэ. Энэ талаар ер нь ямар төсөөлөл байна вэ гэж? Газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх үү? Хуулийн этгээд биш иргэд ихээхэн тариалалт хийж байна. Энэ улсуудыг бид хоршуулж байж, техник, дундын үйлчилгээ юмнуудыг бий болгож байж, сая бүтээмжийн тухай асуудал яригдах юм байна лээ. Энэ тал дээр ер нь ямар бодол байна вэ? Дараа нь нэг зүйл байгаад байгаа юм. Сүүлийн үед энэ хавдар өвчлөл хүнснээс болоод байна гэдэг яриа их явах боллоо. Үүн дээр хийгдсэн.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүнд 1 минут сунгая.

Ж.Батжаргал: Үүн дээр хийгдсэн судалгаа, дүгнэлт байдаг юм уу? Энэ хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний лабораториуд чинь ер нь ямархуу байгаа юм бэ, хил гааль дээрээ ямар байгаа юм бэ, дотоодын үйлдвэрлэл дээрээ ямархуу байгаа юм бэ? Тэр гербицид юмных нь үлдэгдэл юмнууд ямар хэмжээтэй байгаад байгаа юм гэдгийг тогтоосон юм байна уу? Бид ер нь зүгээр дэлхий нийтийн ярьж байгаа хандлагыг дуурайгаад дагаж ярьцгаагаад байгаа юм уу? Үнэхээрийн энэ хүнсний бүтээгдэхүүн дотор чинь хүндрэлүүд байгаад байгаа юм уу? Үүнийг яг ул суурьтай тогтоочихсон шинжлэх ухааны дүгнэлт байна уу? Манай албаны томоохон улсууд ийм юм яриад байх боллоо сүүлийн үед. Энэ чинь эргээд нийт үйлдвэрлэлд чинь сөрөг нөлөө үзүүлнэ шүү. Үнэхээрийн хүнд эрүүл мэндэд таарахгүй, тохирохгүй юм байгаа бол тэрийгээ засах ёстой. Тийм юм байхгүй бол энэ мэдээллийн гажгаа засах ёстой.

Б.Бейсен: 5 номер, Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулъя. Төгсгөлөөс нь эхлээд хариулъя. Болорчулуун дарга тэр тариалалтын сэлгээний ургамалтай холбоотой юмнуудаа яриарай. Энэ хүнсний аюулгүй байдлыг хангуулах асуудал өөрөө яг ингээд ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудал дээр ингээд бүтэн хамаараад ороод ирж байна уу гэхээр дутагдалтай байгаа юм. Ингээд энэ өөрөө салбар хоорондын, дээр нь энэ тогтолцооны өөрчлөлттэй холбоотой асуудлууд байгаад байдаг. Хүнсний тухай хуулиараа ХХААХҮЯ хүнсний хангамж талдаа илүү анхаараад явчихдаг. Мэргэжлийн хяналтын байгууллага бүтэц, чиг үүрэгт нь өөрчлөлт ороод, салбарын хяналтаа чиглээд ирсэн. Энэ дээр технологийн чиглэлийн, худалдааны чиглэлийн энэ хяналтууд нь аюулгүй байдал талдаа ингээд ороод ирчихсэн. Яг эрүүл ахуй талдаа энэ хяналтууд нь байхгүй. Нөгөө талдаа эрүүл, хүнсний эрүүл ахуйн хяналт нь Эрүүл мэндийн яам дээр явж байдаг. Хүнсний аюулгүй байдлыг.../минут дуусав/

Б.Бейсен: Жамбалцэрэн дарга гүйцээж хариулъя, 5 номер.

Т.Жамбалцэрэн: Сүлжээ лабораториудынх нь асуудал. Эдгээр лабораториуд нь, шинжилгээний лабораториуд нь харилцан адилгүй. Гааль гээд нэг өөр тусдаа лабораторитой. Үндэсний лавлагаа лаборатори, 21 аймгийн лаборатори нь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд ингээд явчихдаг. ХХААХҮ-ийн сайдын

эрхлэх асуудлын хүрээнд ганц ажиллаж байгаа лаборатори нь Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори байгаад байдаг. Яг энэ антибиотикийн үлдэгдэлтэй холбоотой гэдэг юм уу, пестицийн үлдэгдэлтэй холбоотой гэдэг юм уу энэ хяналт шалгалт яг энийг тогтоогоод хийчихсэн судалгаа жишээ нь ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага дээр одоогоор байхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ нэгдсэн асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Ерөнхийлөгчийн ажлын албатай хамтраад үндэсний хэмжээний зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тодорхой мэргэжлийн байгууллагууд нь, ЗГ-ын бүтцийн байгууллагууд ороод ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсгийн хүрээнд нэгдсэн судалгаа, тайлан гарна гэж ингэж тооцож байгаа.

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариульъя хариулт.

Ц.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр энэ хаврын тариалалтын ер нь төлөвлөлт гарсан. Улаан буудайг бид 310 мянган га-д тариалъя гэж төлөвлөгөө гараад Хөдөө аж ахуйн корпорац дээр 5900 тонн үрийн улаан буудайн нөөц бүрдүүлээд байна. Тэгэхээр бид ер нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийхээ худалдааг ер нь Хөдөө аж ахуйн биржээр бүгдийг нь гаргаж, нээлттэй борлуулалтыг хийж байгаа. Хэн нэгэн компанийн юм уу, даргын цохолтоор энэ үрийг өгдөг асуудлыг бүхэлд нь халсан байгаа. Тэгээд ингээд 5900 тонн үрийн будаагаа Хөдөө аж ахуйн бирж дээрээ ингээд нээлттэй борлуулалтыг худалдааг явуулахад яг өнөөдрийн байдлаар 1700 тонн л үр борлогдсон байна. Өдийд уг нь хаврын тариалалтдаа бүх ААН-үүд санаа зовоод, санаа тавиад үрээ ингээд гэрээгээ байгуулчихдаг. Тэгэхээр энэ хаврын тариалалтыг хийх, хэрхэн яах, намрын борлуулалт хэрхэн ямархуу үнэ нөхцөлтэй гарахаас хамаараад тариаланчид маань тариалалт дээрээ жоохон хойрго хандаж байгаа.

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариульъя.

Ц.Болорчулуун: Тодорхой биш байгаа учраас энэ асуудал дээр ийм асуудал жоохон хүндрэлтэй байна. Тийм учраас бид хаврын тариалалт төлөвлөсөн хэдий боловч яг яаж, хэрхэн яаж зохион байгуулах тал дээр тариаланчдынхаа асуудлыг бүрэн шийдэхгүй, энэ гаалийн албан татвартай холбоотой асуудлаа нэг талд нь гаргахгүй бол хаврын тариалалтын ажил жоохон бүрхэг талдаа байна гэдгийг хэлье. Тэгэхээр ер нь Хөдөө аж ахуйн биржийг бид нэлээд бирж дээр газар тариалан, мал аж ахуйн гаралтай ийм нийтдээ 28 төрлийн бүтээгдэхүүнийг борлуулах бүх бололцоог нь нээсэн. Биржийн арилжаа маань бүх энэ олон нийтэд нээлттэйгээр ингээд долоо хоногт 2-оос 3 удаа арилжаа хийгдээд явж байгаа. Цаашдаа биржийнхээ тогтолцоог бүрэн бэхжүүлж, бид ерөөсөө бирж дээрээ бүх төрлийнхөө арилжаа хийх энэ боломжийг үүсгэнэ гэж харж байгаа юм. Ингэснээр бид хүнсний гаралтай, хөнгөн үйлдвэрийн гаралтай бүх бүтээгдэхүүнээ Хөдөө аж ахуйн.../минут дуусав/

Б.Бейсен: Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгалын хүрээнд Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолын биелэлтэд бид хяналт тавих, сайдын мэдээллийг сонсохоор ингээд л өнөөдөр хэлэлцэж байна. Гэтэл сайд маань ийм шалтгаантай болчихоод байдаг. Ер нь дараагийн хурал дээр энэ Хүнс, хөдөө аж ахуйн сайдыг биечлэн ирж юу танилцуулах шаардлагатай байгаа. Яагаад гэвэл 3 дахь удаагаа өнөөдөр ийм асуудал гарч байна. Энэ Дарханд нь нүүсэнтэй холбоотой ч байх.

Нөгөө талаар энэ 114 арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч ер нь хэрэгжилт муу байгаа. Зээл 1,2 их наяд төгрөгийн зээл олгоод л, тэрний 23 он гэхэд 832,7 тэрбумын зээл олгосон, хүүгийн дэмжлэг гээд 88,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт олгочоод байгаа. Гэтэл хэрэгжилт муутай. Аймаг, нийслэлийнхэн ажилладаггүй. Хүнс, хөдөө аж ахуйн яамны энэ Хүнсний үйлдвэрлэл, бодлогын хэрэгжилт хариуцсан зохицуулах газрын дарга нь ч энэ ажил жаахан тааруухан хийж байна уу гээд түрүүн гишүүд ярьж байна. Гэтэл энэний гол нь хэрэгжилтийн ажил байгаа. 19 нэр төрлийн бүтээгдэхүүн дотооддоо хангана гээд яриад л байдаг. Гэтэл энэ хангамж муутай, хил гаалиар орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний хяналт шалгалт сул болсон мэргэжлийн хяналт тараасантай холбоотой.

Сая Төрийн нарийн ярьж байна. Лабораторийн тоног төхөөрөмжийг салбар салбар луугаа хуваагаад аваад явчихсан. Хүнсний аюулгүй байдал маань үнэхээр алдагдчихсан. Хавдрын ихсэлт нь 80 хувь нь энэ хүнстэй холбоотой байгаа. Яах вэ 20 хувь нь тэр вирус, удамшлын, тэгээд агаар, бусад асуудал эмийн асуудал гээд бусад асуудал байж байгаа. Би эмч хүний хувьд 35 жил харж байхад ер нь хавдар залуужиж байна, ихсэж байна байнга ярьж байгаа. Цэвэр хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал байна. Химикат ихтэй, генийн өөрчлөлттэй, пестицид ихтэй, тогтворжуулагч бодис гадна орж ирж байгаа бодис юун дээр харагдаж байгаа тогтворжсон бодистой тэр хавдар үүсгэгч гээд тусгай заалттай байгаа. Энэ бүгдийн хяналт алдагдсан.

Ер нь цаашдаа манай Байнгын хороо Засгийн газар, Ерөнхийлөгчид энэ асуудлын талаар саналаа хүргүүлнэ. Лабораторийг шалгачхаж... бол хил гаалиар орж ирж байгаа лаборатори нь баталгаатай юм байхгүй, үнэхээр байдал хүнд байгаа. Тийм учраас энэ хөдөө аж ахуй, ХХААХҮЯ маань энэ дээр анхаарч ажиллаарай. Манай Байнгын хороо хамтраад энэ дээр хамтарч ажиллая.

Нөгөө талаар яг бодит байдал асууя. Яг хүнсний ногооны хэчнээн хувийг импортоор оруулж ирж байна вэ? Жимс жимсгэнэ бараг 100 хувь гадаадаас орж ирж байна. Дотоод яг бодит байдлаар хэдийг хангаж байна вэ? Юун дээр болохоор чинь цаасан дээр буулгасан юмаар чинь тийм юм хангаж байна гээд ярьж байна. Үйлдвэрлэлийн асуудал хэр явж байна энийг асууя.

2 дахь нь малын мал, махны асуудал байж байна. Аймаг, сумдын энэ хүнсний үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүд ажиллахгүй, махны дотоодын мах нөөц махны бэлтгэл ерөөсөө хангагдаагүй, бэлтгээгүй, махны үнэ өндөр болчихсон. Энэтэй холбоотой энэ вакцины асуудал түрүүн оруулж ирж байгаа вакцин ирээгүй байна гээд тийм мэдээлэл авсан. Түрүүн энэ Мал эмнэлгийн газрын дарга бид дуудсан энэ өвчний шалтгаантай байсан юм байна лээ. Вакцин нь орж ирсэн юм уу? Одоо ингээд өвчин гарлаа гэхэд яах юм бэ бид нар. Энэ талаар тодруулж асууя. 7 номер.

А.Нарантуяа: Та бүхэнд Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа. Хүнсний 36 дугаар тогтоолтой холбоотой мал аж ахуйн чиглэлээр мал эмнэлгийн яг мал эмнэлгийн эрүүл мэндийн үйлчилгээнд холбогдсон эрүүл мэндийн асуудалд чиглэгдсэн 4, 5 үйл ажиллагаа байгаа. Тэгээд үүний хүрээнд халдварт өвчнийг өнөөдрийн байдлаар Монгол Улсад 70 хувиар бууруулсан үр дүнтэй байна. Энэ гадаадад гарч байгаа мах, түүний баталгаажуулалт олгох асуудал бол мал эмнэлгийн лабораториуд хэвийн ажиллаж байгаа. Ялангуяа Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори энэ чиглэлээр ажиллаж байна. Ялангуяа олон улсын reference лабораториудад баталгаажуулах, өвчний гаралтыг бууруулах тал дээр мал эмнэлгийн бодлого чиглэл хэвийн явагдаж байгаа.

Тэгээд үүний үр дүнд өнөөдөр Дэлхийн мал, амьтан эрүүл мэндийн байгууллагад шүлхийн хяналтын хөтөлбөрөө илгээсэн байгаа. Тэмцэх арга хэмжээ, стратегийг ЗГ-т хүргүүлсэн. Сайдын зөвлөлд танилцуулсан. Ингээд салбарын хэмжээнд энэ үйл ажиллагаа хэвийн байгаа. Гоц халдварт өвчинтэй тэмцэх 4 өвчин байдаг. Тэгээд үүнтэй 3 өвчний вакциныг та бүхэн мэднэ. Шүлхий, бог малын мялзан, арьс товруутах өвчин. Арьс товруутах өвчин бол өнгөрсөн жил нэг тохиолдол гарсан. Вакцины нөөц байгаа. Бог малын мялзан, шүлхий өвчний нөөцийг хангалттай нөөцөөр 5 тэрбум төгрөгийн худалдан авалтыг явуулж, үүний үр дүнд вакцины нөөц шингэлэгчийн хувьд нөөц хадгалагдсан байгаа.

Харин дотоодын үйлдвэрийн Био үйлдвэрийн вакцин цэцэг өвчний вакциныг үйлдвэрлэдэг Био комбинаттайгаа төрийн өмчит компани байгаа. Үүнтэйгээ хамтарч ажиллаад, вакцины нөөц 25 оны нэмэлт захиалгыг хангалттай хэмжээгээр оны төгсгөлд санхүүгийн асуудлыг зохицуулж, нөөцийг бүрдүүлэн ажиллаж байгаа. Ер нь вакцины үйлдвэрлэл болон захиалгыг өнгөрсөн жил нэмэгдүүлж ажилласан. Ялангуяа био үйлдвэртээ бол бид 5-аас 6 сая тунгаар нэмэгдүүлэн ажилласан байгаа. Тэгэхээр вакцины нөөц дээр тийм дутагдалтай асуудал байхгүй байгаа одоогийн байдлаар. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад гоц халдварт өвчин байхгүй байна. Өнгөрсөн жил та бүхэн мэднэ 10 сард 72 жилийн дараа гарсан ямааны годрон өвчин гараад, 14 хоногийн хугацаанд тэмцэх арга хэмжээг зөв явуулж, ялангуяа оны төгсгөлд ЗГ-ын нөөцөөс болон Улсын онцгой комиссоос нөхөн олговрыг бүтэн олгогдон ажиллаж байна. Тэгээд өнөөдрийн байдлаар өвчингүй, цаг үеийн нөхцөл байдалтай Хөвсгөл аймаг, Өмнөговь, Архангай аймаг, Хөвсгөл аймагт малын галзуу өвчний 1, 2 тохиолдол гарсан тохиолдолтой ажиллаж байна. Ингээд асуултад хариулъя.

Б.Бейсен: Энэ сая би нэг юм буруу танилцуулчих шиг боллоо. Энэ яамны Хүнсний үйлдвэр, бодлого хэрэгжилтийн газар гээд. Энэ хүн амын 50 хувь нь хотод амьдарч байгаа Нийслэлийн хүнсний хангамж хариуцсан албаны даргыг нь ярих гээд л би яамныхыг ярьсан байна, уучлаарай. Тийм учраас энэ асуудал дээр ер нь үнэхээр тааруухан ажиллаж байгаа, бас яамны үгэнд ордоггүй, тавьсан шаардлагыг нь биелүүлдэггүй тийм асуудал байгаа юм байна. Энийг цаашдаа яамныхан анхаарах шаардлагатай. Дараагийн сая түрүүчийн асуултад Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Бейсен гишүүний асуултад тодруулж хариулъя. Хүнсний хангамжийн аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой түрүүн 5 зорилт 114 хэрэгжүүлэх арга хэмжээ гээд ингэсэн. Тэгээд энэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд энэ салбар хоорондын уялдаа, салбар хоорондын хамтын ажиллагаа маш чухал байгаад байгаа юм. Тэгээд энэ төлөвлөгөөгөөр, төлөвлөгөө маань өөрөө их онцлогтой суурь түвшин, зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах төсөв хөрөнгөтэйгөө батлагдсан. Тэгээд энэ чиглэлээр холбогдох энэ чиг үүрэг хүлээсэн байгууллагуудын үр дүнг салбарын яаман дээрээ мониторинг хийгээд аваад үзэхээр харилцан адилгүй дүнгүүд гараад байгаа юм.

Ялангуяа энэ аймаг, нийслэлийн түвшинд энэ орон нутгийнхаа стратегийн хүнсний нөөцийг бүрдүүлэх, аюулгүй нөөцөө бүрдүүлэх, хүнсний хангамж, нийлүүлэлтийн чиглэлээр тодорхой ахиц гаргаж ажиллахгүй бол яг энэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа маань дийлэнх хэсэг нь энэ зээлийн хөрөнгө болоод, ААН-үүдийн зээл болоод, тэгээд хүнсний хангамжийн

нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд явчхаад байгаа юм. Тэгэхээр орон.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулья.

Т.Жамбалцэрэн: Орон нутгийн энэ үүрэг оролцоог нэмэгдүүлэх, энэ үр дүнг нь тооцож, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр онцгой анхаарах шаардлага байна гэдгийг энэ ташрамд хэлэх гэсэн юм.

Нөгөө талаар энэ хүнсний ногооны дотоодын хангамж статистикийн 24 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 65 хувь нь дотоодоосоо хангаж байна, 35 хувь нь импортын хамааралтай гэсэн ийм урьдчилсан дүнгээр байгаа. Энэ дүнг нь хүн амын хэрэгцээ буюу хүн амын жишсэн дунджаар нь аваад үзэхээр харилцан адилгүй үзүүлэлтүүд гарч байгаа. Жимс жимсгэнийн хувьд дотоодын үйлдвэрлэлээр бид 10 орчим хувийг хангаж байгаа, 90 хувь нь импортын хамааралтай байгаа. Орж ирж байгаа импортын энэ жимс, хүнсний ногоон дээр аюулгүй байдлын хяналтыг гаалийн байгууллага гаалийн лабораториор баталгаажуулаад ийм орж ирж байгаа ийм л үзүүлэлт байна.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй. Батжаргал гишүүнээр тасаллаа. Отгонбаяр гишүүн асуулт асууя, үг хэлье.

У.Отгонбаяр: Би энэ хүлэмжийн чиглэлээр ер нь өвөл, зуны хүлэмж, энэ өрхийн үйлдвэрлэл, нэмдэг нь түрүүний миний хэлдэг сургалт. Тэр сургалт нь бол даршлах, нөөцлөх, хадгалах чиглэлийн гээд. Ингээд нэг багцаар нь нэг төсөл хөтөлбөр гэх юм уу эсхүл загвар болгоод юм уу ганц нэг аймаг, сумдыг сонгож авч байгаад нэг ийм ажил зохион байгуулах ер нь боломж бололцоо ер нь байдаг юм болов уу? Тэгвэл манай зүүн бүс бэлэн байна. Сүхбаатар, Хэнтий, Дорнод. Эндээс аль нэг аймгийг нь сонгоод, нэг аймгаас 1 юм уу, 2 сум сонгож аваад энэ хүлэмжийн аж ахуйг өргөжүүлэх, энэ хүлэмжийн аж ахуй хүлэмжид тариалах ногоо, тэгээд энийгээ дагасан даршлах, нөөшлөх ажлыг ингээд цогцоор нь хийж чадвал бид бүхэн энэ хүнсний хангамж, дээрээс нь аюулгүй байдлын чиглэлээр орон нутагт нэлээн дорвитой ажлыг эхлүүлэх ийм боломж бололцоо байгаа гэдгийг би аль, аль талдаа би харж байгаа байх гэж бодож байгаа юм. Тийм учраас энэ чиглэлээр Хөдөө аж ахуйн яам нэг ажил зохион байгуулж өгөхийг хүсэж байна.

Энэ дээр жишээ нь зүүн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд хамтарч ажиллах боломж бололцоо байгаа гэдгийг дуулгамаар байна. Тэгээд энэ дээр дараа нь Хөдөө аж ахуйн яамтай тусгайлан уулзаж, яг энэ хүлэмжийн аж ахуй дээр тодорхой санал санаачилгатай ажилламаар байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Энэ хүнсний хангамж гээд яриад байна. Тэгэхдээ сайн санаачилга боловч уг нь хэрэгжүүлэлт нь юу байна даа, хангалтгүй байна. Манайд сая Бейсен гишүүн ч хэллээ. Ер нь хүнсний аюулгүй байдал алдагдаад байна шүү дээ. Энэ ямар учиртай гэхээр нь та нар мэдэж байгаа малчид болгон тариа, юу вакцин тарьдаг. Тэгээд хамаагүй ингээд хилээс янз бүрийн ямар ч юу байхгүй тодорхой шинжилгээ юунд оруулахгүй газарт авч ирээд нөгөө хорхой шавж гээд юу

цацчихна. Ер нь замбараагаа алдсан байгаа шүү дээ. Мал аж ахуй ч, газар тариалан ч. Энэ юмаа цэгцлэхгүйгээр бид цаашаа явна гэж байхгүй.

Түрүүн Мал эмнэлгийн газарт очиход нэг илтгэл тавихад ярьж байсан л даа. Бид нарт хүн хүч хүрэлцэхгүй байна, мэргэжилтэн хүрэлцэхгүй байна, техникчийн хүрэлцээ муутай байна гээд. Ер нь та нар түрүүн сайд ирэхэд бас би нэг ярьсан юм Байнгын хорооны хурал дээр. Уг нь Орос улстай хамтраад энэ юмаа аль болох нэг эрүүлжүүлэх талаас нь нэг юм бодооч та нар. Орос улстай хамтарна гэхээр зээл авах шаардлага байхгүй. Хамтраад мал аж ахуй, газар тариалан дээр хамтран ажиллаад, эхний ээлжид эрүүл болгох л хэрэгтэй малаа. Тэгж байж энэ хорт хавдар янз бүрийн өвчин зовлонгоос салахгүй бол та нар газар тариа тарина гэж ярина газар нь эрүүл үү, газрын хөрс нь бохирдсон байгаад байгаа шүү дээ. Одоогийн хог хаягдал, одоогийн нөгөө агаарын бохирдол энэ бүхэн энд нөлөөлөөд байгаа.

Тэндээс өвс ургамал идэж байгаа мал бас адилхан. Тэгээд нөгөө газар тариалангаас гарч ирж байгаа нарийн ногоо ч бай аль, аль нь адилхан. Тийм учраас эхний ээлжид авах арга хэмжээ нь ерөөсөө тэр. Малаа, тэгээд газар тариалангаа эрүүлжүүлэх хэрэгтэй. Орос улстай хамтрахад яагаад би Орос гээд яриад байна гэхээр тэд нар болохоор тэр вакцин энэ тэр, тэгээд нөгөө бүх шинжилгээ бүх юуг баттай хийдэг, баталгаатай хийнэ. Тэгээд оронд нь бид заавал яах шаардлага байхгүй мал аж ахуйгаас бүтээгдэхүүн гаргаж болно. Тийм хамтын ажиллагаагаа сэргээгээч та нараас хүсэж байна. Тэгж байж тэгээд энэ газар тариалан энэ тэрээ хөгжүүлэхгүй бол худлаа нэг яагаад хөгжүүлсэн болоод ард түмнийг өвчин зовлонгоор ороолгоод байх шаардлага байхгүй.

Тэгээд 2 дугаарт хэлэх санаа маань энд мал аж ахуйгаас өөр тахианы аж ахуй гээд байсан л даа. Тэрнийг дахиад сэргээмээр байна. Айл болгон өөр өөрсдөө орлоготой, бас ажилтай албатай, тэгээд эдийн засаг сэргээхэд бичил юу нөлөөлнө шүү дээ. Тийм учраас айл болгонд тахиа үржүүлээд энэ гэр хороололд амьдарч байгаа тэгээд өндгөө өөрсдөө хангая ядахдаа. Өндгийг хүртэл бид гадаадаас авч байгаа шүү дээ. Тийм учраас тийм бодитой, бодитой юм хиймээр байна. Та нараас энийг л хүсэж байна шүү. Амжилт хүсье дээ.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн үг хэлье.

С.Ганбаатар: Үг хэлэх боломж өгсөнд баярлалаа. Манай яамныхан нэг зүйл дээр л анхаармаар байна. Хэдүүлээ нэг сэтгэлгээгээ л жоохон өөрчлөхгүй бол болохгүй дээ. Яах вэ хичээлгүй яах вэ бүгд л хичээж байгаа дор дороо. Нөгөө усан онгоц дээр байгаа бүх юмыг л сайхан янзлаад л, цэвэрлээд л, арчлаад л, эмхлээд л байдаг. Даанч усан онгоц буруу тийшээ яваад байна гэдэг шиг л ерөөсөө яриан дунд зээл яаж өгөх вэ, яаж дүүрэн том төхөөрөмжөөр хангачихсан хөдөө аж ахуй, мал аж ахуй. Дүүрэн зээл татаас өгчихсөн. Тэгээд л нэг л болохгүй байгаагийн цаана ерөөсөө экспорт, гадаад зах зээл, Дэлхийн худалдааны байгууллага, бүс нутгийн худалдааны гэрээнүүд, Засгийн газар хоорондын хэлэлцээрт бидний наад ярьж байгаа юмнууд яагаад орохгүй байгаа вэ гэдэг дээрээ онцгой анхаараасай. Энэ шүүмжлэх гэж өнгөөр ярьсангүй. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Хөдөө аж ахуйн байнгын хороо энэ дээрээ анхаарах ёстой. Та нар маань энэ дээр хамтарч ажиллана. Энэ дээр яг яамныхны 100 хувь буруутган гэж ярьсангүй энэ дээрээ төвлөрье.

2 дугаар зүйл. Ер нь зарах асуудал шийдэгдсэн бол бусад юм нь тэгээд л шийдэгдчихдэг юм даа гэж нэг үг бий шүү дээ. Хаана зарах вэ гэдэг тодорхой бол

тэгээд л болоо. Бас ч гэж энэ дээр хичээж байгаа, би ерөөсөө энийг энэ дээр хэдүүлээ бүүр хүчилье гэж байгаа юм шүү.

2 дугаар зүйл технологийн шийдэл байхгүй. Өнөөдөр энэ их том хичээл зүтгэлийн цаана технологийн шийдлүүдээ, технологийн шийдлийг нэг хөдөө аж ахуй, мал аж ахуйн компани очиж шийддэггүй юм. Дэлхийн худалдааны байгууллага, Засгийн газар хоорондын хэлэлцээрээр вакцины технологийг авдаг. Тэр мал нядлах, тэр малын тэр нано технологийн янз бүрийн тэр арьс ширний технологиудыг авдаг. Энэ дээр бид хамтарч ажиллахгүй бол хайран хөдөлмөр хий эргээд л байна.

3 дугаар ажил. Ерөөсөө ярихгүй нэг юм нь боловсон хүчний бодлого. Хөдөө аж ахуйн их сургууль дээр зоо техникийн анги гэж ер нь хүүхдүүд байна уу цаана чинь. Нөгөө 20 хүүхэд ороод 7 хүүхэд төгсөж байна гэж байгаа. Өнөөдөр мал аж ахуйн ангид, малын эмнэлгийн ангид энэ болгон нь бол үнэхээр санаа зовмоор. Ирээдүйд хөрш орноос хүрч ирж зоо техникчид ирж ажиллах нь байна шүү дээ. Энэ 3 дугаарт хүний нөөцийн асуудлыг би ярьж байна шүү. Энэ дээр бид одоо бид анхаарахгүй бол ухаантай царайтай юм ярьж байгаад л бид далаараа тавиулна.

4 дүгээр зүйл. Бидний яриад байгаа татвар, татаас, хөнгөлөлт, хууль, эрх зүйн үйлчилгээ энэ 3-ын дараа яригдана.

5 дугаар зүйл. Одоо бидний байнга ярьдаг зээл тусламж, хөнгөлөлттэй зээл байна уу энэ эхний 3, 4-ийг шийдчихсэн байхад дэлхийгээр нэг зээлээ өгье гээд гүйлдэж орж ирнэ. Гадагшаа хаашаа зарах вэ гэдэг нь тодорхой болчихсон, контрактаа хийчихсэн, технологийн шийдэл гарчихсан, хүний нөөц нь бэлэн болчихсон, эхний 3 жил татварын хөнгөлөлт эдэлнэ гэдэг нь хуульд гарчихсан бол бид татаас, ямар нэгэн хөнгөлөлттэй зээл ч хэрэггүй. Дэлхийн банк өөрөө гүйж орж ирнэ, EBRD, IBRD өөрөө гүйж орж ирнэ. Тэгэхээр энэ 5 бодлого дээр онцгой анхаармаар байна.

Тэгээд эцэст нь нэг зүйл нэмж хэлэхэд найзуудаа яах вэ яам хичээгээд л, Байнгын хороод ч гэсэндээ чармайх л юм даа чааваас. Тэгээд яг малчид, жижиг, дунд үйлдвэрлэгчид, өрхийн аж ахуйтан, аж үйлдвэрлэгч нар энэ салбарын хүмүүстэй бид яг яаж яг чухам үйлчлэх гээд байгаа вэ гэдэг энэ мэдээлэл тэдэнд очихгүй байна. Үнэхээр очихгүй байна. Энэ тал дээр би өөрөө та нартай гар нийлж ажиллана. Тэр хүмүүс нэг татаас зээл, өөр юу ч байдаг юм нэг гоё тэр төрийн гоё үйлчилгээг авахын тулд таньдаг хүнтэйгээ хоолонд орохоос өөр аргагүй байдалд орчих вий гэж би санаа зовдог. Энэ дээр хэдүүлээ хүчилж ажиллахгүй бол болохгүй байна гэсэн ийм 2 санааг би хэлээд, одоо сүүлийн жил хамгийн сайн юм бол уул уурхайг мал.../минут дуусав/

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Хүнсний хангамж, аюулгүй байдал энэ том төлөвлөгөө гайгүй хэрэгжиж байгаа. Би энэ хөдөө аж ахуйн салбарынханд талархалтай байгаа гэдгийг зориуд хэлэх ёстой. Хэдүүлээ илүү анхаарах ёстой зүйлүүд байна. Тэгэхээр энэ нэг бий болчихоод байгаа нөөц боломжуудыг хүнс болгох, баялаг болгох тал дээр л бид илүү анхаарах ёстой. Хэдүүлээ сүүний бодлого ярихаараа зөвхөн шингэн сүүнийхээ бодлогын бүс нутаг ярьцгаагаад байгаа улс байхгүй юу. Тэгвэл сүүн бүтээгдэхүүн гэж өчнөөн юм байгаад байна шүү дээ. Тэгвэл тэр шингэн сүү болгож татаж авч чаддаггүй тэр бүс нутгууддаа тэр сүүн бүтээгдэхүүнийхээ үйлдвэрийг хөгжүүлье л

дээ. Наад бяслаг гэдэг чинь хэчнээн ч нэр төрлийн юм байгаад байгаа юм. Наад тараг бүтээгдэхүүн гэдэг чинь хэчнээн ч нэр төрлийн юм байгаад байгаа юм. Түүнийгээ тэр бүс нутгууддаа хөгжүүлж байж, сая тэр алслагдмал бүс нутгийн малчид, иргэдийг бид орлогожуулах ёстой. Нэгэнт байж байгаа бүтээгдэхүүний нөөцийг нь баялаг болгох ёстой. Энэ тал руу нэлээн сайн анхаарч байж энэ хөдөө аж ахуйн салбарын, хүнсний салбарын, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил өөрөө урагшилна. Энэ тал руу нэлээн анхаармаар байна гэдгийг нэг ийм юм хэлмээр байна.

2 дахь миний хэлмээр байгаа зүйл хүнс үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын бүх түвшинд нь хяналт үнэлгээ, шинжилгээгээ хийгээд, хаанаа ямар асуудал байгаа юм бэ гэдгээ тодорхойлоод, тэр байгаа яг тэр технологийн үйл явц дээр нь стандарт хангалтаа хийх тухай асуудал л байгаа. Ер нь явж, явж энэ хүнсний аюулгүй байдлаар дамжиж өвчлөл, хавдар өргөжиж байгаа, залуужиж байгаа тухай их ярьцгаах юм бол наадах чинь үйлдвэрлэлтэд ч, экспортод ч нэлээн том цохилт болно шүү. Тийм учраас үүнийг яг бодитой дүгнэлтийг нь гаргаж, алдаа оноо байгаа бол засаж залруулах юмаа хийх ёстой. Мэдээллийн гажиг байгаа бол засах ёстой юмаа хийх ёстой. Энэ ер нь энэ салбарын амин сүнс асуудал нь шүү. Үүнийг хийхгүйгээр бид болохгүй байна.

Манжинг бид юу болдог гэж ярьцгаагаад манжингаа унагачихлаа. Энэ зах зээлийн эхэн дээр. Үгүй ээ тэгээд одоо тэгээгүй л байна шүү дээ. Манжин ер нь хүнийг аваад явчихдаг эд, хавдрыг үүсгэдэг эд гэсээр байгаад манжингийн тариалалтаа устгачихсан улс шүү дээ бид. Үгүй ээ тэгсэн гэдгийг хэн тогтоосон юм. Нэг иймэрхүү яриануудад би ярьж байгаа яриаг нь буруу гэхгүй байгаа юм. Тэр шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан тэр нотолгоонуудаа гаргаж ирж засах залруулах ёстой юмаа хийх ёстой. Тэгж байж цаашаагаа энэ үйлдвэрлэл юм чинь цэгцтэй зөв хөгжих тухай асуудал байгаа.

Дараагийн нэг хэлчихмээр байгаа зүйл энэ хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарт судалгаа хөгжүүлэлтийг эрс нэмэгдүүлмээр байна. Байгалийн өөрийнх нь өгөгдөл энерги гэж байдаг. Үүнийг нь түшиглэж үйлдвэрлэлээ явуулах тухай асуудал. Тэгж байж нэгж бүтээгдэхүүний өртөг зардлыг хямдруулах тухай асуудал байдаг. Би магадгүй энэ өвлийн хүлэмжийн тухай ярьцгаагаад байгаа юм. Олигтой үр дүнд хүрч өгөхгүй байгаа юм. Үгүй ээ тэр байгалийн дулааны эх үүсвэрийг нь ашиглаад энэ говийн бүс рүү өвлийн хүлэмжээ суурьшуулбал яасан юм. Бүхэл бүтэн хэдэн сая тонноор нь шахуу нүүрс ачиж ирээд, эндээ хэдүүлээ түлээд болж байгаа юм чинь хэдэн хүлэмжийн.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дуусаж байна. Би нэг саналаа хэлээдэхье. Ер нь энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой манай хүнсний хангамж, аюулгүй байдал, хангамжийн талаар авах арга хэмжээний хүрээнд энэ 37 дугаар, 36 дугаар тогтоолын биелэлт дээр ер нь яам, аймаг, нийслэлийн хэмжээнд хяналт тавихгүй бол ажлыг эрчимжүүлэхгүй бол хүнсний аюулгүй байдал алдагдаж байгаа нь үнэн үү гэвэл үнэн байх. Ялангуяа Улаанбаатар хотын тэр хүнсний энэ үйлдвэрлэл хариуцсан бодлого, хэрэгжилт хариуцсан улсууд ерөөсөө муу ажиллаж байна. Нөгөө талаар зөвхөн хүнсний асуудалд тэр тариалж байгаа хүнсний ногоондоо биш, худалдаа юугаар ирж байгаа баахан чихэр, жимс, шоколадны асуудал байж байна. Ундааны асуудал байж байна. Хавдар өсөж бойжсон. Жишээлбэл энэ дээр нэг ярих асуудал байж байна л даа. Зарим эмнэлгийн байгууллагуудын шинжилгээгээр энэ ундаа, чихэр, шоколадтай холбоотой хавдар үүсгэж байна гэсэн асуудал гарч

байгаа. Сахрын өвчинд нөлөөлж байна гэдэг асуудал үүсэж байгаа. Энэний хяналт шинжилгээ дээр анхаарч ажиллах шаардлагатай байгаа.

Нөгөө талаар энэ хүнсний хүлэмжийн, хүнсний ногооны хүлэмжийн асуудал. Энэ дээр анхаараад л жаахан жишээлбэл хавар 10 сар хүртэл, 10-аас намар 10 сараас 11, 12, 1, 2 сар, 3 сар хүртэл өвлийн хүйтэн үед хүлэмжийн аж ахуй, өвлийн хүлэмж ажиллуулахад манай Монгол Улсын нөхцөл байдал ч тийм байгаа. Тэгэхээр чинь бүрэн дулаан хангамжтай хүлэмжийн аж ахуй, 4 сараас хойш тасралтгүй ажиллуулдаг хүлэмжийн аж ахуй гээд та нар юун дээрээ тусгаад нэг ажил зохион байгуулах нь чухал юм шиг байгаа юм.

Нөгөө талаар жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлээр очиж байгаа зээл тусламж ерөөсөө чанаргүй, жижигхэн хэмжээний талбай дээр хүлэмжээ харуулаад их хэмжээний зээл авчихдаг хангалт муу. Энэ дээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Ер нь аймаг, нийслэлийн хэмжээнд хяналт тавьж ажиллаад, Монгол Улсын хэмжээнд хүнсний ногоогоор бүрэн хангах боломж байгаа гэж бодож байгаа. Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаач гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаар талх гэхэд 2500-аас 4000 хүрчихсэн байна шүү дээ, сүү гэхэд 4800 литр нь, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн нэмэгдсэн. Нөгөө талаар аюулгүй байдал нь алдагдчихсан. Энэ асуудал дээр салбарын эрүүл мэндийн байгууллагууд, хил гаалийнхантай манай Хөдөө аж ахуйн яамныхан хамтарч ажиллах шаардлагатай. Бид энэ хугацаанд энэ завсарлагааны хугацаанд хил гааль, боомт дээр очиж ажиллах, яамны улсуудтай хамтраад энэ ажлыг хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллая гэдэг санал хэлье.

Нөгөө талаар энэ хадгалалт, ногооны хадгалалтын асуудал байж байгаа хүнсний ногооны. Намар бид Дарханд уулзахад тариаланчид хэлж байсан шүү дээ ерөөсөө. Бид тариалдаг, гэтэл авдаггүй. Эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнс авдаггүй гээд. Гэтэл энэ сургууль, цэцэрлэг, дотуур байр энэ тэр хямдхан хятад хүнсний ногоо авдаг их хэмжээгээр. Энийг Боловсролын яамтай хамтарч бодлого болгоод боловсруулаад эх орны хөрсөнд ургасан, тариаланчид маань тариалсан хүнсний ногоо, төмс, байцай, лууван, сонгино энэ тэрийг хадгалах нөөцлөх тийм зоорь юуг нь битүүлээд, тариаланчид маань тариалсан хүнсний ногоог чинь худалдаж авах, цаанаа улсаас засгаас тавьсан төсөв нь байж байгаа. Тэрний хүрээнд энийг хангах боломж байгаа байх. Тэгж байж дотооддоо хүнсний ногоо тариалах асуудал нэмэгдэх байх гэж бодож байна миний хувьд.

Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаач гэдгийг хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа та бүгдэд. Гишүүд үг хэлж дууслаа. Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Ирж мэдээлэл сонсгосон, тайлбар хийсэн ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

13.34 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн асуудал. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах асуудлыг хэлэлцье. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолыг та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээ байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Цагаанхүү Идэрбат Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Жигжидийн Батжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн, Р.Сэддорж Улсын Их Хурлын гишүүн, Ухнаагийн Отгонбаяр Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтны тухай бүр татан оролцуулахыг Ажлын хэсэг Цагаанхүүгийн Идэрбат зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөл дээр саналтай гишүүн байна уу? Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Манай энэ Байнгын хороон дээр байгуулж байгаа ажлын хэсэг чинь ЗГ-аас өргөн барьсан нэмэлт, өөрчлөлтийн хуулийн ажлын хэсэг байна шүү дээ. Тэгэхээр бид дээр Их Хурал дээр юу гэж тохирсон бэ гэхээр энэ гуравхан заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Хаврын, энэ намрын чуулган дуусаад, хөдөөгүүр явж малчдаас асуугаад, шинэчилсэн найруулгын хэмжээнд өөрчилье. Тэр ажлын хэсгээ Улсын Их Хурал дээр тусдаа байхгүй юу. Энэ Засгийн газрын өргөн барьсныг хэрвээ унагаачих юм бол тэр өдөр унагаах боломж байсан. 1 жилийн туршид дахин шинэчилсэн найруулгын төсөл өргөн барьж болохгүй байсан. Тэгэхээр яг ингээд нөгөө нэг яг сайхан тэр Улсын Их Хурлын ажлын хэсэг өөрчлөн найруулга дээр ажиллах ёстой гишүүд маань ЗГ-ын нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсэгт орчхоод байх юм. Бөөндөө энэ туршлагатай гишүүд, тойргоос сонгогдсон гишүүд юун дээр орохгүй юм уу Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулах өөрчлөн найруулах ажлын хэсэгт орохгүй байсан юм уу? Биш ээ, шинэчлэн найруулах тийм.

Тэгэхээр энэ чинь Засгийн газрын нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсэг байхгүй юу, гуравхан заалт. Үзэл санааг нь бид баталчихсан болохоор наад 3 заалт дотор чинь л явна биз дээ. Тэгээд би нөгөө гишүүдэд тэрийг л сануулах гээд. Улсын Их Хурлаас байгуулж байгаа тэр найруулга чинь өргөн цар хүрээтэй шүү дээ. Тэгэхээр яваандаа хамтатгах нь гэж үү, нэгмөсөн шууд нөгөө томдоо ороод явахгүй юм уу? Тийм үү? Нийлчих юм уу, тэгээд 2 хуулийн өөрчлөлтөө нийлүүлчих юм уу? За, байрлалаа.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Би миний ойлгосноор сая Батжаргал гишүүний хэлж байгаа энэ 2 чинь явж байгаад сүүлдээ нийлээд нэг болоод ингээд явах ёстой гэж ойлгосон. Засгийн газар, Их хурлын ажлын хэсэг 2. Энд байгуулагдсан ажлын хэсэгт орсон гишүүд давхар Их Хурлын даргын захирамжаар байгуулагдах ажлын хэсэгт орж болно биз дээ? Би уг нь болох ёстой гэж ойлгоод энд орж байгаа. Болохгүй гэсэн юмаа? Болохгүй гэсэн юм байхгүй. Тэгнэ. 2 ажлын хэсэг 2 талаасаа нэгтгэгдээд, энэ чинь нэг хуулийн төсөл болоод явна гэж ойлгосон. Тийм биз дээ Батжаргал ах?

Б.Бейсен: Ингэж ойлгосон шүү дээ. Ер нь Засгийн газраас гарсан, Их Хурлаас гарсан ажлын хэсэг сүүлдээ нэгтгээд энэ нэгэнт батлагдаж байгаа хууль дээр нэгтгээд санал оруулах, нэгдэх байх гэж ойлгосон шүү дээ. Тийм учраас энэ тийм юм оруулахгүй байх гэсэн ийм заалт байхгүй байх. Ганбаатар гишүүн асуулт асууна гэсэн үү? За. Тогтоолын, тогтоолын төслийг Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Бат-Эрдэнэ гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя. 69,2 хувиар санал хураалт дэмжигдлээ.

13.41 цаг

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж, хэрэгжүүлж байгаа төслийн хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах асуудлыг хэлэлцье.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл болон, та бүгдэд уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар сонссонтой холбогдуулан дээрх салбаруудад хэрэгжиж байгаа олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Сайнхүүгийн Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, гишүүдэд М.Ганхүлэг Улсын Их Хурлын гишүүн, Сонгобайн Замира Улсын Их Хурлын гишүүн, М.Мандхай Улсын Их Хурлын гишүүн, Р.Сэддорж Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Улсын Их Хурлын гишүүн, Б.Уянга Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэгт Сайнхүүгийн Ганбаатарт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдолтой саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй байна.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Батжаргал гишүүн, Отгонбаяр гишүүн хоёрыг дэмжсэнээр протоколд тусгая. Санал хураалт 61,5 хувиар дэмжигдсэн тул, санал хураалт дэмжигдээд санал хураалт дууслаа.

13.44 цаг

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Дараагийн асуудал оръё. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцын үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн удирдамж батлах тухай асуудлыг хэлэлцье.

Ажлын хэсгийн удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Энэ тогтоолын төслийг уншиж танилцуулга та бүгдэд тараачихсан байгаа, танилцуулчихъя. Тийм ээ, тараачихсан шүү дээ бүгдэд нь. Тийм үү? Ажлын хэсгийн удирдамж батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос, хорооны 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн тогтоолоор байгуулсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар сонссонтой холбогдуулан дээрх салбаруудад хэрэгжиж байгаа олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн удирдамжийг удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн танилцуулах санал дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт

заасны дагуу бэлтгэж, хэлэлцүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Сайнхүүгийн Ганбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй байна. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Ганбаатар гишүүн, Найдалаа гишүүн 2-ыг дэмжсэнээр авъя. Тогтоолын төсөл 53,8 хувиар батлагдсан тул санал дэмжигдлээ.

13.47 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Хуралдаанд оролцсон, идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА